



**ҮАГ-ын 2006 оны бүтээгдэхүүн, ажил,
үйлчилгээний төлөвлөгөөний дагуу
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**

**АНУ-аас Монгол Улсад үзүүлж
буй улаан буудайн тусламж**

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Хоёрдугаар газар

Тэргүүлэх аудитор

О.Мэндбаяр

Ахлах аудитор

Ц.Гэрэл

Аудитор

З.Цээнээ

Шинжээч:

Л.Эрдэнэчулуун

Р.Цолмон

Зөвлөх:

ИБУИНВУ-ын ҮАГ-ын Тэргүүлэх

аудитор

Сюзан Свинглер

Төслийн дотоод

Зөвлөх

Д.Хангал

2006 оны 8 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын

Веб сайт-аас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар

Засгийн газрын 4 дүгээр байр,

Бага тойруу-6, Улаанбаатар-46

Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга

зүй, стандартын мэдэгдэл 4

Бүлэг 1

Улаан буудайн төсөл иргэдэд ашиг тусаа өгсөн хэдий ч илүү олон хүмүүсийг хамрах боломж байжээ

- Оршил 5
- Улаан буудайн тусламжийн өнөөгийн байдал 6
- Хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт туслах нь улаан буудайн төслийн зорилго байв 6
- Улаан буудайн үнэ өндөр тогтоогдсон, гэхдээ үнэлсэн арга нь төслийн зорилго, тусламжийн гэрээтэй нийцэж байна 6
- Улаан буудайн чанарыг хянаж шинжлэх тогтолцоо хангалттай байжээ 7
- Улаан буудайн борлуулалтыг хэлэлцээрийн дагуу удирдаж байсан ч эрсдэл арилаагүй байна 7
- Хөгжлийн төслүүдийн ашиг тусыг олон иргэд хүртсэн 8
- Хөгжлийн төслүүд илүү олон хүмүүсийг хамрах боломжтой байсан 9
- Хөгжлийн төслүүдийн зарим санхүүжилт саатаж байжээ 10
- 2000 оны зарим санхүүжилт хэлэлцээрийн дагуу хийгдээгүй байна 11

Агуулга

- 2002 оны улаан буудайн борлуулалтын орлогын 90 гаруй хувийг АНУ-ын ОУХА-ийн хөтөлбөрт ашиглажээ 12
- Бага хүүтэй зээл олгох нөхцөл бүрдүүлэх зорилт хэрэгжээгүй байна 13
- АНУ-ын Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, технологийг сурталчлах төслийн мөнгөний зарцуулалтад хяналт тавиагүй байна 13
- Мерси Кор 2005 оноос дотоод хяналттай болсон ч хөгжлийн төслүүд хөндлөнгийн хяналтгүй байна 13
- Мерси Корын өгсөн мэдээлэл гүйцэтгэлийг үнэлэхэд хангалтгүй байсан 13
- 2003 оноос хойш төсөл хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар оролцоогүй байна..... 15
- Улаан буудайн борлуулалтын орлогоос Хас банкинд оруулсан хөрөнгийг хэлэлцээр дуусахад татаж аваагүй байна 15
- АНУ-ын улаан буудайн төсөлтэй холбоотой залилангийн эрсдэлүүдийг үр нөлөөтэй үнэлж, удирдаагүй байна 15
- Залилангийн талаархи олон нийтийн санаа бодолд яамд соргог хандах хэрэгтэй 17
- Залилангийн эрсдэлийг удирдахын тулд яамд зохих арга хэмжээг авах хэрэгтэй 18
- Зөвлөмж** 19

Бүлэг 2

Улаан буудайн төсөлд тавих Засгийн газрын хяналт шинжилгээ хангалтгүй байжээ

- Оршил 14
- Тайлагнах тогтолцоо оновчтой байсан ч хяналт шинжилгээ хийх үүрэг хариуцлагыг орхигдуулжээ 14
- Монгол Улсын Засгийн газрын байгууллагууд улаан буудайн төслийг хянаж шинжлэх үүргээ биелүүлээгүй байна 14

Холбогдох байгууллагын санал:

- Сангийн яамнаас ирүүлсэн санал 20
- Гадаад хэргийн яамнаас ирүүлсэн санал 21
- Мерси Кор ТББ-аас ирүүлсэн санал 22
- Саналд өгсөн тайлбар** 38
- Хавсралт** 43

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГХЯ	Гадаад хэргийн яам
СЯ	Сангийн яам
СЭЗЯ	Санхүү, эдийн засгийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ДБЯ	Дэд бүтцийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ТХШХ	Төрийн хянан шалгах хороо
ОУХА	Олон улсын хөгжлийн агентлаг
ХААД	Хөдөө аж ахуйн департамент
ЭСЯ	Элчин сайдын яам
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ГТХС	Газар тариалан хөгжүүлэх сан
ХАБДХ	Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр
ГБЭЗХС	Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага
ХАҮТ	Худалдаа, аж үйлдвэрийн танхим
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
АХБ	Азийн хөгжлийн банк
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

Аудитын арга зүй



Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15.1.4-д заасан "... олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн бусад байгууллагад олгосон зээл, тусламж, хандивын ашиглалт, зарцуулалт, үр дүнд аудит хийх" Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү аудитыг хийв.

АНУ-аас Монгол Улсын Засгийн газарт улаан буудайн тусламж үзүүлэх талаар хоёр орны Засгийн газар хооронд 2000, 2002, 2003 онд байгуулсан хэлэлцээрүүдийг хэрхэн үр нөлөөтэй, үр ашигтай удирдаж, хянаж байсныг шалгаж, холбогдох дүгнэлт, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- o Мерси Кор болон Сангийн яамны Зээл тусламжийн нэгдсэн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтнүүдээс ярилцлага, асуулга лавлагаа, судалгаа, тоон мэдээлэл авах,
- o АНУ болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг судлах,
- o Монгол Улсын ГХЯ, СЯ, Монголбанк болон Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ-наас асуулга лавлагаа авах,
- o Мерси Корын үйл ажиллагааны тайланг судлах,
- o Төслийн хэрэгжилтийг хэлэлцээрийн зорилттой харьцуулах,
- o Улаан буудайн борлуулалт болон түүний орлогоор хэрэгжүүлж байгаа хөгжлийн төслүүдтэй холбогдсон баримт материалтай танилцах.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

АХБ-наас хэрэгжүүлж буй "Засаглалын шинэчлэлийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийн гадаад зөвлөх, Нэгдсэн Вант Улсын Үндэсний аудитын газрын тэргүүлэх аудитор Сюзан Свинглер, төслийн дотоод зөвлөх Д.Хангал нар аудитын багт зөвлөгөө өгч ажиллав.

Бүлэг 1: Улаан буудайн төсөл иргэдэд ашиг тусаа өгсөн хэдий ч илүү олон хүмүүсийг хамрах боломж байжээ

Оршил

1.1. Энэ аудитаар АНУ-ын “Хүнс - хөгжил дэвшлийн төлөө” хэмээх 1985 оны хуулийн дагуу Монгол Улсын Засгийн газарт АНУ-аас улаан буудайн тусламж үзүүлэх тухай Монгол Улс, АНУ-ын Засгийн газар хооронд 2000, 2002, 2003 онд байгуулсан хэлэлцээрүүдийг хэрхэн удирдаж, хянасныг шалгав.



1.2. Хэлэлцээрүүдэд Монгол Улсын ГХЯ, АНУ-ын ЭСЯ-ны төлөөлөгч нар гарын үсэг зурсан. Хөтөлбөрт ХХААЯ, ДБЯ зэрэг Монгол Улсын байгууллагууд тухай тухайн үед оролцож байжээ. АНУ-ын талаас АНУ-ын ХААД улаан буудайн тусламжийн хөтөлбөрийг АНУ-ын ОУХА-тай хамтран зохион байгуулсан байна.

Хэлэлцээрүүдэд дор дурдсан АНУ-ын улаан буудайн тусламж тусгагджээ:

Он	Тонн ¹	Борлуулалтын орлого ² (тэрбум төгрөгөөр)
2000	40,000	4.8
2002	25,000	3.4
2003	24,500	3.6
Дүн	89,500	11.8

1.3. Хэлэлцээрүүдийг Монгол Улсын ГХЯ, АНУ-ын ЭСЯ-наас томилогдсон төлөөлөл бүхий гурван гишүүнтэй Удирдах зөвлөл удирдаж байсан. Гурав дахь төлөөлөл нь 2000, 2002 онд ХХААЯ, 2003 онд Хойд Америк-Монголын бизнесийн зөвлөл байв.

1.4. Монгол Улсын Засгийн газар Монголын гурилын компаниудад улаан буудай борлуулах, орлогыг нь Монголд хэрэгжүүлэх хөгжлийн төслүүдэд хуваарилах ажлыг зохицуулах төлөөлөгчөөрөө MercyCorps International (Мерси Кор Интернэйшнл) хэмээх ашгийн бус сайн дурын байгууллагыг 2000 оны 11 дүгээр сард томилжээ. Мерси Кор нь түүнчлэн хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхээр Удирдах зөвлөлийн сонгосон гол байгууллага нь байв. World Vision (Дэлхийн Зөн), PACT, Land O'Lakes (Лэнд О' Лэйкс), CHF International (Си Эйч Эф Интернэйшнл) зэрэг сайн дурын бусад байгууллагууд ч хөгжлийн төслүүдэд зориулж улаан буудайн борлуулалтын орлогоос тодорхой хэмжээний санхүүжилт авсан байна. Хэлэлцээр ёсоор Монгол Улсын Засгийн газар АНУ-ын ХААД-д тайлан гаргаж өгөх ёстой байсан. Сонгосон сайн дурын байгууллагууд уг тайланг гаргаж байжээ. 2000-2003 онд ГХЯ тайлангуудын хувийг авч байсан. Харин 2003 оноос хойш хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотой тайлангуудыг СЭЗЯ-д өгч иржээ.

¹ АНУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын 2000, 2002, 2003 оны хэлэлцээрүүд

² Эх үүсвэр: Мерси Корын тайлан

Улаан буудайн тусламжийн төслийн өнөөгийн байдал

1.5. 2004 оноос хойш АНУ-аас улаан буудай хандивлах талаар хоёр орны Засгийн газруудын хооронд хэлэлцээр хийгдээгүй байна. Одоогийн байдлаар АНУ-ын ХААД “Хүнс-хөгжил дэвшлийн төлөө” хөтөлбөрийн дагуу Монголд ашиглах зорилгоор хандивыг сайн дурын байгууллагуудад шууд олгож байна. Гэхдээ 2000, 2003 оны хэлэлцээрээр нийлүүлсэн улаан буудайн борлуулалтын орлогоор санхүүжсэн хөгжлийн төслүүд одоо ч үргэлжлэн хэрэгжиж байна.

1.6. АНУ-аас үзүүлэх эдийн засаг, техникийн болон холбогдох бусад бүх тусламж АНУ, Монгол Улсын Засгийн газар хооронд 1992 онд байгуулсан хэлэлцээрээр зохицуулагдах бөгөөд энэ дагуу АНУ-ын тусламж импортын татвар болон бусад аливаа татвар хураамжаас чөлөөлөгддөг.

Хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт туслах нь улаан буудайн төслийн зорилго байв

1.7. АНУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын 2000, 2002, 2003 оны хэлэлцээр ёсоор АНУ-ын улаан буудай нь Монгол Улсад өгсөн буцалтгүй тусламж байсан боловч ядуусыг хооллох, хямд үнээр борлуулахад чиглэгдээгүй юм. АНУ улаан буудайгаа хүнсний тусламжийн хөтөлбөр бус харин “Хүнс-хөгжил дэвшлийн төлөө” хөтөлбөрийн хүрээнд хандивласан байна. Хөтөлбөр нь хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэхэд Монгол Улсын Засгийн газарт туслах зорилгоор боловсруулагдсан. Борлуулах зориулалттай улаан буудайг Засгийн газарт буцалтгүй тусламж хэлбэрээр хандивлах замаар АНУ хөгжлийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг гаргаж өгч байжээ. Энэ улаан буудай нь хямд үнээр борлуулж, улаан буудайн дотоод, гадаад арилжааны эх үүсвэрийг нөхөх буюу зах зээлээс шахах зориулалтгүй юм.

Харин улаан буудайн борлуулалтын орлогоос бүрдэх мөнгийг Монгол Улсын Засгийн газрын дэмжсэн хөгжлийн тодорхой төслүүдэд ашиглах зорилготой байв.

1.8. Улаан буудайн төслийн зорилгыг олон нийтэд сайтар мэдээлж байгаагүй бөгөөд энэ нь ч улаан буудайн төслийг хүнсний тусламжийн хөтөлбөр мэтээр ойлгосон байсан, одоо ч тийм хүлээлт байгаа талаархи хэвлэлийн нийтлэлээс харагдаж байна.

Улаан буудайн үнэ өндөр тогтоогдсон, гэхдээ үнэлсэн арга нь төслийн зорилт, тусламжийн гэрээтэй нийцэж байна

1.9. Хэлэлцээрийн нөхцөл ёсоор Удирдах зөвлөл “улаан буудайн борлуулах үнэ болон хуваарилалтыг шийдвэрлэж, борлуулалтын үйл явцыг хэрэгжүүлэх талаар Мерси Корт заавар өгч, хэлэлцээрийн хэрэгжилтийг ерөнхийд нь хянан”. 2000 оны хэлэлцээрт улаан буудайг тендерээр зарна гэж заасан хэдий ч Мерси Корын тайланд дурдсанаар 2000 оны 12 дугаар сард үнийн саналуудыг нээхэд нэг нь ч хүлээгдэж байсан зах зээлийн үнийн түвшинд хүрээгүй байна.

1.10. Удирдах зөвлөлийн 2001 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөр огноолсон тайланд дурдсанаар улаан буудайг тонн тутмыг нь 115,000 төгрөгөөр зарахыг Мерси Корт зөвшөөрсөн санамж бичигт Удирдах зөвлөлийн гишүүд 2000 оны 12 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зуржээ.

Харин 2001 оны 1 дүгээр сарын 25-нд Удирдах зөвлөл тонн тутмын үнийг 120,000 төгрөгөөр тогтоох шийдвэр гаргасан байна. Үүний улмаас томоохон худалдан авагчид

2000 оны улаан буудайнаас их хэмжээгээр авахаа больсон боловч улаан буудай бүрэн борлогджээ.

Хэлэлцээрийн он	Тендерт оролцогчдын тоо
2000	Томоохон худалдан авагчид улаан буудайг их хэмжээгээр худалдаж аваагүй учир жижиг худалдан авагчид худалдаж авах боломж гарсан. 161 худалдан авагчтай 316 гэрээ хийгдсэн.
2002	Худалдан авагчид нийт байгаа 25 000 тонноос илүү хэмжээний улаан буудай худалдаж авах санал ирүүлсэн. Үүнд нийт 19 боломжит худалдан авагч байснаас 7 нь тендерийн санал өгч, 4 нь тэнцсэн.
2003	Боломжит худалдан авагчид нийт байгаа 24 500 тонноос илүү хэмжээний улаан буудай худалдаж авах санал ирүүлсэн. Худалдан авагчдын тоог заагаагүй.

Эх үүсвэр: Мерси Короос АНУ-ын ХААД-д өгсөн 2000, 2002, 2003 оны тайлангууд

1.11. 2000 оны борлуулах үнийг хэрхэн тооцоолсныг Мерси Кор тайлбарлаагүй. Харин Мерси Корын 2003 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөр огноолсон дотоод тайланд ХААД-ын улаан буудайн үнийг 2003 онд тонн тутамд 140,000 төгрөгөөр тогтоосныг тайлбарласан байна. Тухайлбал, уг тайланд “энэ үнэ дотоодын зах зээлийн түвшний хувьд өндөр талдаа орох боловч дотоодын улаан буудайн зах зээлийн үнийг эвдэхгүй бөгөөд улаан буудайн зах зээлийн эцсийн үнэнд сөргөөр нөлөөлөхгүй” гэж бичжээ. Тайланд мөн дараахь зүйлийг дурджээ:

- Дотоодод зарах үнэ тонн нь 130,000 - 135,000 төгрөг,
- Японы тусламжийн улаан буудайн зарах үнэ тонн нь 138,000 төгрөг байв.
- Улаан буудайг 132,500 –140,000 төгрөгийн хооронд борлуулах боломжтой гэж Европын Холбооны үр тарианы шинжээч нар Мерси Корт зөвлөсөн.

Улаан буудайн чанарыг хянаж шинжлэх тогтолцоо хангалттай байжээ

1.12. Улаан буудайн чанарыг ХАУТ-ын экспорт импортын барааны магадлан шалгах газар, Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, УМХГ гэсэн гурван байгууллага хянаж шинжилж байсан. Эдгээр гурван байгууллага өөр өөрсдийн чанарын шалгалтын үр дүнд үндэслэн гэрчилгээ олгож байсан. Түүнчлэн улаан буудайг худалдаж авсан гурил үйлдвэрлэгч компаниуд улаан буудайн чанарыг хянаж шинжлэх тоног төхөөрөмжтэй байсан бөгөөд өөрсдөө үнэлгээ хийж байсан нь гэрчилгээ олгосон байгууллагуудынхтай тохирч байжээ. Чанарын хяналтын энэ тогтолцоог хангалттай ажиллаж байсан гэж бид үзлээ.

Улаан буудайн борлуулалтыг хэлэлцээрийн дагуу удирдаж байсан ч эрсдэл арилаагүй байна

1.13. АНУ-ын тусламжийн улаан буудай гол төлөв гурил үйлдвэрлэгч компаниудад зарагдаж, борлуулалт нь хүлээгдэж байсан орлогын 98%-д хүрсэн. Хэлэлцээрт гурил үйлдвэрлэгч компаниудыг дурдсан боловч гурил үйлдвэрлэдэггүй компаниудад зарахгүй гэж тусгайлан заагаагүй. 2000 онд улаан буудайн борлуулалтыг зөвхөн гурил үйлдвэрлэдэг компаниудаар хязгаарлахгүй байхыг Удирдах зөвлөл Мерси Корт зөвшөөрсөн байна³.



³ Удирдах зөвлөлийн 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэл

1.14. Улаан буудайг гурил үйлдвэрлэгч компаниудад гол төлөв борлуулсан боловч гурил үйлдвэрлэдэггүй компанид зарсан, уг улаан буудайг архи хийхэд ашигласан байж болзошгүй юм. Хэлэлцээрээр улаан буудай, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дахин борлуулах буюу экспортлох, аль эсвэл дотоодынхоос өөр зориулалтаар ашиглахыг хориглосон. Гэтэл Мерси Кор ч, Монгол Улсын Засгийн газар ч тусламжийн улаан буудай, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлохоос сэргийлэх шалгалт хийсэн гэх нотлох зүйл бидэнд олдоогүй бөгөөд улаан буудай, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлосон байж болох эрсдэл бий.

1.15. Мерси Кор 2003 оны 11 дүгээр сард гаргасан дотоод тайландаа “цаашдаа, борлуулсан барааг зөвхөн хүнс хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар ашиглана гэж борлуулалтын дүрэмд зааж өгөх нь зүйтэй. Энэ нь улаан буудай зэрэг бараа зөвхөн хүнсний хэрэглээний зориулалтаар ашиглагдах бөгөөд согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглагдахгүй байхад тусална” гэж тэмдэглэжээ. Энэ өөрчлөлтийг хийх чиглэлийг АНУ-ын ЭСЯ-наас өгсөн гэж Мерси Кор мэдэгдсэн.

Хөгжлийн төслүүдийн ашиг тусыг олон иргэд хүртсэн

1.16. Гурван удаагийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих гол төслүүдийг дор жагсаав:

Улаан буудайн борлуулалтын орлогоос санхүүжигдэх хөгжлийн төслүүд		
2000 он	2002 он	2003 он
<ul style="list-style-type: none"> • Фермийг зах зээлтэй холбох замын төсөл • Амьжиргааг дэмжих төсөл - мал аж ахуй - усжуулалт - зээл олголт • “Цагаан хувьсгал” сүүн бүтээгдэхүүний төсөл • Гамшгийн дараах тусламж • Хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, технологийн төсөл • Энх тайвны корпусын орон нутгийн иргэдэд чиглэсэн төслүүд • Хөдөө аж ахуйн салбарын сурталчилгаа 	<ul style="list-style-type: none"> • Хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр - мал аж ахуйн менежмент - бэлчээрийн нөөцийн менежмент - усны нөөцийн менежмент - үйлдвэрлэлийг дэмжих - Гамшгийн дараах тусламж 	<ul style="list-style-type: none"> • Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр - Сургалт, зөвлөгөө - Хөдөөгийн бизнес мэдээ - ХАА-н сэдэвт радио нэвтрүүлэг • Хотын бизнес хөгжлийн төсөл - Үйлчлүүлэгчид сургалт явуулан, зөвлөгөө өгөх - Жижиг бизнесийг шинээр эхлүүлэх ба өргөжүүлэх - Зээл олгох - Ажлын байр бий болгох

Эх үүсвэр: АНУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын 2000, 2002, 2003 оны хэлэлцээрүүд

1.17. Бид 2000, 2002, 2003 оны хэлэлцээрт тусгагдсан хөгжлийн төслүүдийг Мерси Кор хэрхэн хэрэгжүүлснийг шалгасан (Зарим төслийн, жишээлбэл Хотын бизнес хөгжлийн төслийн хэрэгжүүлэгч нь Мерси Кор байгаагүй). Аудитын үр дүнг дор толилуулав:

1.18. Мерси Корын тэмдэглэснээр Хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2002 онд хэрэгжсэн хөгжлийн төслүүд дараахь зүйлийг хамарсан:



- 1,892 оролцогчдыг хамруулсан мал аж ахуйн менежмент, малын үүлдэр угсааг сайжруулах 75 сургалт
- малчид, мал эмнэлгийн үйлчилгээг холбоход туслах
- мал өсгөхтэй холбоотой техникийн туслалцаа
- ноолуур, малын гаралтай бүтээгдэхүүний яармаг худалдааг дэмжих
- сард 60-70,0 мянган хувь хэвлэгддэг орон нутгийн бизнесийн сэтгүүлийг дэмжих
- телевиз, радиогийн малчдын хөтөлбөрийг нэмэгдүүлэх
- 22,000 мал, 140,000 га газар бүхий 120 өрхийг хамарсан бэлчээр, усны менежментийг сурталчлах хоёр төслийг хэрэгжүүлэх



1.19. Бид ХАБДХ-ийн хүрээнд 2003 онд хэрэгжсэн хөгжлийн төслүүдийг Сүхбаатар, Архангай, Дорноговь, Ховд, Завхан аймагт шалгасан. Төслүүд төлөвлөсөн ёсоор үр нөлөөтэй хэрэгжиж 3000 гаруй малчдад дараахь ашиг тус өгч байгаа нь шалгалтаар тогтоогдлоо:

- бизнесийн ур чадвар,
- малчид хамтран ажиллахын ашиг тус,
- өрхийн эдийн засаг, бизнесийн төлөвлөлт,
- бэлчээрийн менежмент,
- малын үржил, тэжээлийн үйлдвэрлэлийн чиглэлээрх сургалт.

1.20. 2003 онд санхүүжилт авсан дараахь төслүүдийг бид шалгасан:

- “Вэт-нэт” төсөл - малын эмч нарыг сургаж, эм оношлуур нийлүүлэх
- “Сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдал” төсөл – 4 газарт сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сурталчлах,
- “Говийн бэлчээр” төсөл – бэлчээрийн менежмент
- Хөдөө аж ахуйн сэдэвт мэдээллийг хэвлэн нийтлүүлэх



Ихэнх төсөл 2005 оноос хэрэгжиж эхэлсэн учир тэдгээрийн үр нөлөөг үнэлэхэд хэт эрт байна. Учир нь 2003 оны улаан буудайг монголд 2004 онд хүлээн авч 5 сарын турш борлуулсан юм.

Хөгжлийн төслүүд илүү олон хүмүүсийг хамрах боломжтой байсан

1.21. Улаан буудайн төслийн зорилтууд төдийлөн хангалттай биелээгүйг аудитаар илрүүлсэн. Тухайлбал:

2000 он

- “Цагаан хувьсгал” сүүн бүтээгдэхүүний төсөл сүүний чиглэлийн мал, сүүн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хэрэглээг дэмжих зорилготой юм. 2000 оны борлуулалтын орлогын 10 хувийг энэ төсөлд хуваарилжээ.

- Сүүн ферм ажиллуулахын тулд борлуулалтын орлогоос Шинэ Зеландын бизнес эрхлэгчийг дэмжсэнийг аудитаар илрүүлсэн. Зээлээ эргэн төлмөгц бизнес эрхлэгчийн өмчид үлдэх үхэр, бусад хөдлөх хөрөнгө худалдан авахын тулд Мерси Корын батлан даалтаар Хас банкнаас авсан зээлээр энэ бизнес санхүүжжээ.
- Тухайлбал, Мерси Кор уг төслийн хэрэгжүүлэгчээр Шинэ Зеландын хөрөнгө оруулалттай Алпайн ХХК-ийг тендергүй сонгосон бөгөөд үүнийгээ “сүүний ферм үүсгэн байгуулах, удирдах чадвартай, Монголд цорын ганц дадлага туршлага бүхий хүн удирдаж буй Алпайн ХХК-ийг сонгосон” гэж тайлбарласан ч аудитын явцад энэ давуу тал ажиглагдсангүй.
- АНУ-ын ХААД-д өгсөн Мерси Корын 2000 оны тайланд “Үйл ажиллагаа нь сайжирч буй сүүн фермийн менежмент, үр дүнг ажиглахад ойр хавийн зарим малчид худалдан авалт, хангалттай нэмэлт тэжээл бэлтгэх зэрэг шилдэг туршлагаас нь нэвтрүүлжээ”, “орон нутгийн ажилтнуудад байшин барьсан”, “2005 оны 8, 9 сард 60 үнээнээс 7200 литр сүү сааж анхны борлуулалт хийсэн” гэж бичсэн хэдий ч малчдыг өргөнөөр оролцуулсан ямар нэгэн албан ёсны сургалт хийгээгүй, байшин бариагүй, сүү борлуулсан баримт, саалийн хэрэгсэл байхгүй, үнээний ашиг шим нь муу байна.
- Хугацаа хойшилсноос төслийн хэрэгжилт одоо ч эхлэл төдий байна. Хэрэв төсөлд малчдыг илүү өргөн хамруулж сургалт зохион байгуулахгүй бол төсөл дуусахад Шинэ Зеландын нэг иргэн 500 үнээтэй болж, цөөн хэдэн монголчуудыг хөлслөн, улаан буудайн борлуулалтын орлогын 625,8 сая төгрөгөөр ашигтай бизнес хийсэн гэсэн гол үр дүн гарах эрсдэл байна.

2002 он

- Төсөлд хамрагдсан хүмүүсийн тоо 2002 оны хэлэлцээрт тусгагдсан түвшний 30 орчим хувь байгаа нь ихээхэн доогуур үзүүлэлт юм. Гэхдээ ГХЯ 2002 оны төслүүдийг хэрхэн хэрэгжүүлэх талаар Мерси Корт чиглэл өгсөн бөгөөд тэрхүү чиглэл нь 2002 оны хэлэлцээрт заасан төсөлд хамрагдах хүмүүсийн тооноос зөрүүтэй байжээ.

2003 он

- АНУ-ын ХААД-д өгсөн Мерси Корын 2003 оны тайлан зардал, цаг хугацааны хувьд дэвшүүлсэн зорилтууд хэрхэн биелж байгааг тодорхойлоход хангалтгүй мэдээлэл агуулжээ. Төсөлд хамрагдсан хүмүүсийн тоо зорилтот түвшинтэй харьцуулахад ихэвчлэн доогуур байсан. Гэхдээ ГХЯ 2003 оны төслүүдийг хэрхэн хэрэгжүүлэх талаар Мерси Корт чиглэл өгсөн бөгөөд тэрхүү чиглэл нь 2003 оны хэлэлцээрт заасан төсөлд хамрагдах хүмүүсийн тооноос зөрүүтэй байжээ.
- Си-Эйч-Эф-ийн төслийн талаар тайлагнах үүргийг Мерси Кор хүлээгээгүйгээс АНУ-ын ХААД-д өгсөн Мерси Корын 2003 оны тайланд Си-Эйч-Эф-ийн хэрэгжүүлсэн зарим дэд төслийн санхүүжилт, үр дүн бичигдээгүй байлаа. Тухайлбал:
 - Бий болгосон ажлын байр ба ажилд оруулсан хүн
 - Жижиг бизнесийг өргөжүүлсэн ба сайжруулсан үзүүлэлт
 - Шинээр эхлүүлсэн жижиг бизнес

Хөгжлийн зарим төслийн санхүүжилт саатаж байжээ

2000 он

1.22. Фермийг зах зээлтэй холбох замын төсөл, Цагаан хувьсгалын сүүн бүтээгдэхүүний төслийн санхүүжилт хоёр жил хоцорч хийгджээ. Тэдгээрийг 2001 оны 3 сараас хэрэгжүүлэх байсан боловч 2003 оны 3 сар хүртэл санхүүжилт хийгдээгүй бөгөөд Цагаан хувьсгалын сүүн бүтээгдэхүүний төслийн санхүүжилт одоо ч бүрэн хийгдээгүй байна. Төслүүдийг хэрхэн зохион байгуулах, мөнгийг хэрхэн зарцуулах талаар Удирдах зөвлөлийн шийдвэр удаж гарч байснаас ийнхүү саатсан гэж Мерси Корынхон тайлбарласан.

Фермийг зах зээлтэй холбох замын төсөл:

- 2003 онд АНУ-ын ЭСЯ төслийн тендер зарласан боловч шаардлага хангасан санал ирээгүйгээс Си-Эйч-Эф хэмээх сайн дурын байгууллагад уг ажилд зориулсан мөнгийг тендергүй олгожээ. Гэтэл энэ мөнгийг зам сайжруулах ажилд ашиглалгүй, гэр хорооллын жижиг, дунд бизнес хөгжлийн төсөлд зарцуулжээ. Бид энэ төсөлд аудит хийгээгүй.

Цагаан хувьсгалын сүүн бүтээгдэхүүний төсөл:

- 2005 оны мал тооллогоор төлөвлөсөн 500 үхрээс 55 тугал, 56 өсвөр үхэр, 117 үнээ, 5 бух, нийт 233 толгой үхэр тоологдсон байна. Аудит хийх үед 358.7 сая төгрөг зарцуулагдаагүй байв.

2002 он

- Улаан буудайн борлуулалтын хөтөлбөрийн менежер өмнөх онд нь авилгалын хэрэгт орооцолдсон учир АНУ-ын Элчин сайд 3 сая ам. долларын улаан буудайн орлогыг хуваарилахыг хойшлуулсан гэж Мерси Корын 2002 оны тайланд бичжээ.

2000 оны зарим санхүүжилт хэлэлцээрийн дагуу хийгдээгүй байна

1.23. Борлуулалтын орлогын 50% -ийг фермийг зах зээлтэй холбох замын төсөлд, 20%-ийг амьжиргааг дэмжих төсөлд ашиглах ёстой байсан. Фермийг зах зээлтэй холбох замын төслийн санхүүжилтийн 50 хувийг 2001 оны 5 дугаар сард, үлдсэнийг нь 45 хоног тутамд 15 хувиар олгох, амьжиргааг дэмжих төслийн санхүүжилтийн 50%-ийг 2001 оны 4 дүгээр сард, үлдсэн 50%-ийг 2001 оны 7 дугаар сард хоёр хувааж олгох ёстой байсан.

1.24. Мерси Кор 2000 оны хэлэлцээрийн дагуу малын менежмент, усны үйлчилгээ, худаг засварын ажлыг санхүүжүүлээгүй болох нь аудитаар тогтоогдлоо. ХААД-д өгсөн тайландаа Мерси Кор “худагны сэргээн засварлалт, сургалтын үйл ажиллагааг дараа нь өөр хөтөлбөрөөр санхүүжүүлсэн” гэжээ. Энэ нь АНУ-ын ОУХА-ын бусад хөтөлбөр ойролцоо үйл ажиллагаа явуулж байсан учир улаан буудайн борлуулалтын орлогыг 2000 оны хэлэлцээрт заасны дагуу ашиглахгүйгээр шийдсэн байж болох юм.

1.25. АНУ-ын ХААД-д өгсөн тайландаа Мерси Кор “өмнөх онуудад бүртгэгдсэн нийт 888.8 сая төгрөгийг ГБЭЗХС хөтөлбөрийн үйл ажиллагаа (114,8 сая төгрөг) болон говийн санаачлага төслийн хүрээнд “Говийн эхлэл” жижиг зээлийн үйлчилгээг дэмжихэд (774,0 сая төгрөг) ашигласан” гэжээ. Энэхүү ГБЭЗХС хөтөлбөр нь АНУ-ын ОУХА-ын хөтөлбөр бөгөөд энэ нь үнэн хэрэгтэй мөнгийг 2000 оны хэлэлцээрт тусгагдаагүй Америкийн төсөлд шилжүүлсэн гэсэн үг юм. Дээрх 114,8 сая төгрөгийн 3.1 сая төгрөгийг Говийн санаачлага хөтөлбөрийн ажилтнуудын цалинд ашиглаж, 111,7 сая төгрөгийг Мерси Корын АНУ дахь төв аппарат руу шилжүүлснийг аудитаар илрүүлээ.

1.26. Ашгийн бус байгууллага болох Мерси Кор Говийн санаачлагын хүрээнд “ашиг олох” банкны үйл ажиллагаанд хөрөнгө оруулжээ. Тухайлбал, хувьцаа эзэмшихийн тулд улаан буудайн борлуулалтын орлогын 16.5%-тай тэнцэх 774,0 сая төгрөгийг Хас банкинд оруулсан байна. Хас банкны Захирлуудын зөвлөлд Мерси Корын зарим ажилтан төлөөллөөр орж, цалин, ноогдол ашиг авч байжээ. Монгол банкнаас авсан тодруулгаар Мерси Кор нь Хас банкны дүрмийн сангийн 18,4 хувийг эзэмшиж байна.

1.27. Дээрх 774.0 сая төгрөгийг Мерси Корын санхүүгийн тайланд авлага болон урт хугацаат хөрөнгө оруулалтын аль ч хэлбэрээр тусгалгүй, шууд зардалд тайлагнасан нь буцааж авах ёстой хөрөнгө гэдгийг илэрхийлж чадахгүй байна.



1.28. “Хас банкнаас эхний жилүүдэд ногдол ашиг аваагүй, банкныхаа дүрмийн санг Монгол банкнаас заасан хэмжээнд хүртэл өсгөх шаардлага байсан, 2005 онд 72,0 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсныг Хас банкинд ажилладаг гадаадын зөвлөх, ТУЗ-ийн дарга нарын зардалд зориулсан” гэж Мерси Корын удирдлага хэлсэн.

1.29. Хөрөнгө оруулалт хийсэн мөнгийг “шаардлагатай үед татан авч өөр төсөлд зарцуулна” гэж Мерси Корын удирдлага хэлсэн. Гэтэл хэлэлцээрээр зорилт бүрийг санхүүжүүлэх хувийг тодорхой зааж өгч, нийт дүнг 100%-д тулгаж бариулаад байхад ийнхүү тайлбарлаж байгаа нь ойлгомжгүй юм. Иймд улаан буудайн борлуулалтын орлогоос Хас банкинд хөрөнгө оруулалт хийсэн нь 2000 оны хэлэлцээрийг зөрчсөн гэж дүгнэж байна. Мөн фермийг зах зээлтэй холбох замын төсөлд зарцуулах мөнгийг гэр хорооллын жижиг, дунд бизнес хөгжлийн төсөлд зарцуулсан нь ч дээрх хэлэлцээрийг зөрчжээ.

2002 оны улаан буудайн борлуулалтын орлогын 90 гаруй хувийг АНУ-ын ОУХА-ийн хөтөлбөрт ашиглажээ

1.30. 2002 оны улаан буудайн орлогын 90 гаруй хувь ба 3,0 тэрбум төгрөгийг Мерси Кор болон АНУ-ын ОУХА-ын хамтран хэрэгжүүлсэн ГБЭЗХС хөтөлбөрийн тав дахь жилийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашигласныг аудитаар илрүүллээ. Энэ санхүүжилтийг ГХЯ зөвшөөрсөн бөгөөд улаан буудайн төсөл, ГБЭЗХС хөтөлбөрийн зорилтын хооронд үл авцалдах зүйл үгүй. Гэхдээ улаан буудайн орлогыг хэлэлцээрт заасны дагуу хэрэглэж, ГБЭЗХС хөтөлбөрийг АНУ-ын ОУХА өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бол монголын иргэд хоёр дахин илүү тусламж авах байжээ.

1.31. Монгол Улсын Засгийн газар болон Мерси Корын хооронд байгуулсан гэрээнд борлуулалтын орлогын 95 хувийг мал аж ахуйн менежмент, бэлчээрийн нөөцийн менежмент, усны нөөцийн менежмент, хувийн хэвшлийн менежментэд тэнцүү хуваан зарцуулахаар тусгажээ. Гэтэл 2002 оны борлуулалтын орлогын 95 хувь буюу Мерси Корын зарцуулах хөрөнгөд 3070,5 сая төгрөг төвлөрч, үйл ажиллагааны буюу шууд бус зардалд 85 хувийг, үлдэх 15 хувийг хөтөлбөрийн зардалд зарцуулсан байна. Энэ нь Хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрийн 4 хэсэгт тэнцүү хувааж зарцуулах гэрээний заалтыг зөрчсөн байна.

1.32. Нийт үйл ажиллагааны зардалд 56 хувь эзэлж буй Улаанбаатар дахь үйл ажиллагааны зардал болох 1308,7 мянган долларын зарцуулалтаас:

- o 41.9 мянган долларыг Мерси Корын ажилтнуудын ажилгүйдлийн даатгалын санг 1999 оны 5 дугаар сараас байгуулаагүй байсныг нөхөн байгуулж зардалд бичсэн;
- o “Хурд хүнс” ХХК-иас УАЗ 31519 маркийн 3 автомашин 13,8 мянган доллароор, “SIS” ХХК-иас LandCruiser 105GX маркийн 4 автомашиныг 132,2 мянган доллароор худалдан авсан;
- o Мерси Корын ажилтнуудын цалинг нийт 8.5 мянган ам доллараар нэмсэн;
- o 36.5 мянган доллароор албан тасалгааны тавилга, техник хэрэгсэл бэлтгэсэн гэх мэт зардлууд гарчээ.

Бага хүүтэй зээл олгох нөхцөл бүрдүүлэх зорилт хэрэгжээгүй байна

1.33. Зээлийн баталгааны хөтөлбөр 2003 оны борлуулалтын орлогоос 384,0 сая төгрөгөөр 11 банк ба ББСБ-д 80 орчим зээлд зориулж баталгаа гаргах ба үүнд 11 хүртэлх аймгийн 64 бүлэг, хоршоо буюу 2560 хүн, 16 бизнес буюу 160 хүн хамруулахаар төлөвлөжээ. Энэ хөтөлбөрт зээлийн хугацааг уртасгах, хүүг багасгах, зээлдэгчдэд илүү ашигтай нөхцөл бүрдүүлэх зорилттой байсан ч банкуудтай байгуулсан гэрээнд дээрх нөхцөлүүд тухайлбал, зээлийн хүү бага байх заалт тусгагдаагүй байна.

1.34. Монгол Улсын Засгийн газар болон Мерси Корын хоорондын гэрээгээр 2003 оны зээлийн баталгаа хөтөлбөр 2006 оны 1 дүгээр сард хугацаа дууссан тул нэмэлт барьцаа хэлбэрээр банкуудад байршуулсан 393,0 сая, Алпайн ХХК-ийн зээлийн барьцаанд байршуулсан 198.2 сая төгрөг, нийт 591.2 сая төгрөгийг Монгол Улсын Засгийн газарт буцааж өгөх ёстой.

АНУ-ын Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, технологийг сурталчлах төслийн мөнгөний зарцуулалтад хяналт тавиагүй байна

1.35. Мерси Кор 2003 оны хэлэлцээрийн АНУ-ын ХАА-н бүтээгдэхүүн, технологийг монголд сурталчлах зорилтыг хэрэгжүүлэхээр Газар тариалан хөгжүүлэх сан ТББ-тай гэрээ хийж, төслийн менежерээр АНУ-ын иргэн Жим Двайрыг ажиллуулжээ. Үүний дагуу ГТХС-д 45 сая төгрөг шилжүүлсэн боловч зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд нь хяналт тавиагүй байна.

1.36. Аудитаар Жим Двайрын цалинд сар бүр 2.4 сая төгрөг олгож, төслийн мөнгөний 44 хувь буюу 19,8 сая төгрөг зарцуулсан, бусад зардлын ихэнх нь баримтгүй байв. АНУ-ын ХАА, хүнсний салбарын 100 гаруй томоохон аж ахуй нэгжийн үйлдвэрлэдэг техник, технологи, бүтээгдэхүүнийг судалсан мэдээллийн сан бүрдүүлсэн эсэхийг үзэх гэхэд компьютер эвдэрсэн гээд үзүүлээгүй болно.

Мерси Кор 2005 оноос дотоод хяналттай болсон ч хөгжлийн төслүүд хөндлөнгийн хяналтгүй байна

1.37. 2005 оноос өмнө Мерси Кор дотоод хяналтын зохих системгүй байсныг аудитаар илрүүлсэн. 2005 оноос Мерси Кор дотоод аудитортой болсон нь үр нөлөөтэй дотоод хяналтыг бүрдүүлж өгчээ. Гэхдээ хөгжлийн төслүүд хөндлөнгийн хяналтгүй байгаа нь хяналтын нийт системийн үр нөлөөг бууруулж байна.

Мерси Корын өгсөн мэдээлэл гүйцэтгэлийг үнэлэхэд хангалтгүй байсан

1.38. Мерси Корын 2002, 2003 оны тайланд тусгагдсан мэдээлэл нь борлуулалтын орлогыг ашиглах чиглэлийг мөрдсөн эсэх, төслийн шалгуурууд бүрэн хангагдсан эсэхийг гол сонирхогч талууд болох ГХЯ, АНУ-ын ЭСЯ, АНУ-ын ХААД тодорхойлоход хангалтгүй байжээ. Энэ нь дэд төслүүдэд зарцуулсан мөнгө болон төсөлд хамрагдагсдын тоог тэр бүр бүртгэдэггүй байсантай холбоотой.

1.39. АНУ-ын ХААД-д өгсөн 2000 оны тайланд амьжиргааг дэмжих төслийн мөнгийг ашгийн төлөө ажилладаг хувийн Хас банкинд оруулж, үүний дагуу Мерси Кор гол хувьцаа эзэмшигчдийн нэг болж, ТУЗ-д төлөөллөө оруулж, цалин, ноогдол ашиг авах эрхтэй болсон, зээл олгох үйлчилгээ нь Хас банкны үйлчилгээтэй ямар холбоотойг бичээгүй. Мөн 2002 оны тайланд улаан буудайн борлуулалтын орлогын 90 гаруй хувийг АНУ-ын ОУХА-ын Говийн санаачлага хөтөлбөрийн тав дахь жилийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашигласнаа бичээгүй.

Бүлэг 2: Улаан буудайн төсөлд тавих Засгийн газрын хяналт шинжилгээ хангалтгүй байжээ

Оршил

2.1. Энэ бүлэгт Монгол Улсын Засгийн газар, түүний томилсон төлөөний агент - Мерси Короос улаан буудайн тусламжийн ашиглалт, зарцуулалтад тавьсан хяналтыг авч үзсэн. АНУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Гадаад хэргийн сайд гарын үсэг зурсан бөгөөд ГХЯ улаан буудайн төслийн хэрэгжилтийг Монголд голлон хариуцах үүрэг хүлээжээ.



Тайлагнах тогтолцоо оновчтой байсан ч хяналт шинжилгээ хийх үүрэг хариуцлагыг орхигдуулжээ

2.2. АНУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр Удирдах зөвлөл улаан буудайн үнэ тогтоох, хуваарилах шийдвэр гаргаж, Мерси Корт борлуулалтын менежерийнх нь хувьд заавар өгөх үүрэг хүлээжээ. ГХЯ улаан буудайг борлуулах, орлогыг төвлөрүүлэх үүргийг Мерси Корт өгсөн байна.

2.3. Улаан буудайн төслийн хэлэлцээрээр Мерси Кор:

- о улаан буудайг хүлээн авч, борлуулах ажлыг зохион байгуулах
- о санхүүгийн болон борлуулалтын тайлан гаргаж АНУ-ын ЭСЯ, Монгол Улсын Засгийн газарт хүргүүлэх
- о орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөлд хамрагдах хүмүүсийг сонгох
- о орлогыг зарцуулах
- о улаан буудайн орлогоор санхүүжигдсэн үйл ажиллагааны талаар Удирдах зөвлөлд бүрэн мэдээлэл өгч, зөвлөлдөж байх үүрэг хүлээжээ.

2.4. Тайлагналын энэ тогтолцоо оновчтой бөгөөд улмаар төсөлд сайтар хяналт шинжилгээ хийх боломжийг Монгол Улсын ГХЯ-нд олгохуйц байжээ. Гэвч яам өөрийн үүрэг хариуцлагыг буюу өөрөөр хэлбэл улаан буудайн төслийг хянаж шинжлэхэд ямар тогтолцоо, горим шаардлагатайг бүрэн ойлгоогүй байна. Энэ зорилгоор ямар нэгэн тогтолцоо, горим журам огт боловсруулаагүй ажээ.

Монгол Улсын Засгийн газрын байгууллагууд улаан буудайн төслийг хянаж шинжлэх үүргээ биелүүлээгүй байна

2.5. АНУ, Монгол Улсын Засгийн газрын хооронд эдийн засаг, техникийн болон бусад тусламжийн талаар 1992 онд байгуулсан хэлэлцээрт “Монгол Улсын Засгийн газар ... ийм тусламжийг үр нөлөөтэй ашиглах талаар зохих арга хэмжээ авна” гэж заажээ.

2.6. ГХЯ болон СЭЗЯ улаан буудайн төсөлд ямар ч хяналт шинжилгээ хийгээгүй нь аудитаар тогтоогдлоо. Хэдийгээр Мерси Кор ГХЯ-ны нэрийн өмнөөс тайлан гаргаж АНУ-ын ХААД-д хүргүүлж байсан ч, ГХЯ-ны нэг ч ажилтан уг тайлангийн агуулгыг хэрэгжилттэй нь харьцуулан, алдаа мэдгийг нь хянаж байсангүй. Тиймээс улаан буудайн санг буруу ашигласныг олж тогтоохгүй, засаж залруулахгүй байх эрсдэл байжээ.

2.7. 2000, 2002, 2003 оны хэлэлцээрийн дагуу аймаг, орон нутгийн удирдлага Мерси Кор болон сайн дурын бусад байгууллагаас орон нутагт хэрэгжүүлж буй хөгжлийн төслүүдийн явц, үр дүнг хянах үүрэгтэйг ГХЯ-наас мэдэгдээгүй байна. Тиймээс аймаг, орон нутгийн удирдлага хөгжлийн төслүүдийг огт хянаагүй байна.

2003 оноос хойш төсөл хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар оролцоогүй байна

2.8. 2003 оноос хойш ГХЯ улаан буудайн төсөлд оролцоогүй байна. Уг үүрэг хариуцлага СЭЗЯ-нд шилжсэн ба Мерси Корын тайлангийн хувийг СЭЗЯ хүлээн авч байв. Хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өдөр тутмын яриа хэлцэлд Монгол Улсын Засгийн газар оролцохоо больсон ч 2000, 2002, 2003 оны улаан буудайн борлуулалтын орлогоор санхүүжсэн төслүүдийн зарим нь үргэлжлэн хэрэгжиж, зарим нь дөнгөж эхэлж байв. Энэ нь ихэнх төслийг хэрэгжүүлүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас томилсон төлөөний агент болох Мерси Кор Монгол Улсын Засгийн газрын хяналт удирдлагагүйгээр шийдвэр гаргаж, төслүүдийг хэрэгжүүлж байсан гэсэн үг юм. Энэ нь дотоод хяналт, хариуцлагыг сулруулан, зүй бус үйл ажиллагаа хийгдэх, илрэхгүй байх эрсдэлийг ихэсгэжээ.

Улаан буудайн борлуулалтын орлогоос Хас банкинд оруулсан хөрөнгийг хэлэлцээр дуусахад татаж аваагүй байна

2.9. АНУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын жил тутмын хэлэлцээрийг 2003 оны эцсээс дахин байгуулаагүй ажээ. Тэр үед АНУ-аас Монгол Улсын Засгийн газарт хандивласан улаан буудайн борлуулалтын орлогоос 774,0 сая төгрөгийг Мерси Кор Хас банкинд хөрөнгө оруулалт болгоод хийчихсэн байсан. Энэ мөнгө бол Монгол Улсын Засгийн газрын хөрөнгө болохоос Мерси Корын хөрөнгө биш юм. Тиймээс АНУ, Монгол Улсын Засгийн газар хоорондын жил тутмын сүүлийн хэлэлцээр дуусах үед Монгол Улсын Засгийн газар уг мөнгийг “Хүнс – хөгжил дэвшлийн төлөө” хэмээх 1985 оны хуулийн дагуу Монголд ашиглахаар эргүүлж өгөхийг шаардах эрхтэй байсан. Гэтэл ГХЯ мөнгийг буцааж авах талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

2.10. 2000, 2002, 2003 оны хэлэлцээрийн дагуу улаан буудайн орлогын 591.2 сая төгрөг зээлийн барьцаанд ашиглагдаж байгаа бөгөөд энэхүү мөнгийг зээл нь эргэн төлөгдөхөд мөн эргүүлж татах ёстой.

АНУ-ын улаан буудайн төсөлтэй холбоотой залилангийн эрсдэлүүдийг үр нөлөөтэй үнэлж, удирдаагүй байна

2.11. 1990-ээд оны сүүлчээр Монгол Улсын ХХААЯ улаан буудайн төслийн хэрэгжүүлэгч байхад АНУ-ын улаан буудайг худалдан авагчид залилан, зүй бус үйлдэл хийсэн талаар мэдээлэл гарч байсан. АНУ-ын Элчин сайдын хүсэлтээр Монгол Улсын ТХШХ (хуучин нэрээр) 1997 оны тусламжийн улаан буудайг хүлээн авч, орлого бүрдүүлсэн байдалд шалгалт хийж, шалгалтын дүнгээр ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга ажлаасаа халагдсан. АНУ-ын ХААД-д өгсөн Мерси Корын 2002 оны тайланд өмнөх онд нь улаан буудайн борлуулалтын хөтөлбөрийн менежертэй холбоотой авилгалын хэрэг гарсныг дурдсан нь зүй бус үйлдлийн өөр нэг жишээ юм.



2.12. ТХШХ (хуучин нэрээр) 2000 оноос өмнөх үед улаан буудайн төслийн хувьд залилангийн эрсдэл байсныг ийнхүү тайлагнасан бөгөөд тиймээс ГХЯ залилангийн

эрсдэл байгааг мэдэж байсан боловч улаан буудайн төслийн залилангийн эрсдэлүүдийг авч үзээгүй буюу тэдгээр эрсдэлийг удирдах стратеги боловсруулаагүй байна. ГХЯ улаан буудайн борлуулалт, борлуулалтын орлогын холбогдолтой банкны гүйлгээ, зарлагууд, улаан буудайн ашиглалт болон дэд төслүүдийн үр дүнг шалгах зэрэг залилангийн эрсдэлийг бууруулах ямар нэгэн хяналт тогтоогоогүй байна. Үүний улмаас залилан, зүй бус ашиглалт гарч, илрэхгүй дарагдах эрсдэл байна.

2.13. Залилангийн эсрэг арга хэмжээ авахгүй байх нь төрийн байгууллагын нэр хүнд, шударга байдал, мэргэжлийн түвшинд сөргөөр нөлөөлж, олон нийтийн итгэлийг алдахад хүргэж болно. Эрсдэлийг хэрэв үнэлсэн бол эрсдэл бүхий гол хэсгүүд, эрсдэлийн түвшин, тэдгээр эрсдэлийг удирдах арга хэмжээг дараахь байдлаар тодорхойлох боломжтой байжээ:

Тогтолцоо буюу үйл явц	Эрсдэлийн тодорхойлолт	Эрсдэлийн түвшин			Эрсдэлийг удирдах буюу бууруулахад шаардагдах арга хэмжээ (Өртгийн хувьд үр нөлөөтэй тохиолдолд)
		Бага	Дунд	Их	
Улаан буудайг агуулах руу тээвэрлэх	Улаан буудайг дотооддоо тээвэрлэх явцад алдагдах эрсдэл	БАГА: Ихэнх тохиолдолд улаан буудайн алдагдал 1% буюу түүнээс ч бага байсан учир эрсдэл бага байсан <i>Эх үүсвэр: Мерси Корын тайлан</i>			Хүлээж авсан улаан буудайн хэмжээг илгээсэн болон импортолсон хэмжээтэй харьцуулах. Улаан буудайг буулгах, тээвэрлэхэд хяналт тавих
Улаан буудайг борлуулахаас өмнө хадгалах	Борлуулахаас өмнө хадгалалтын явцад улаан буудай алга болох эрсдэл	БАГА: Улаан буудайн алдагдал: 2000, 2002 – 1.4% 2003 – 1% -иас бага (агуулахад хадгалалгүй шууд хүргэсэн) <i>Эх үүсвэр: Мерси Корын тайлан</i>			Агуулахад байгаа улаан буудайн түвшинг шалгах 1.4% алдагдал гарах боломж олгосон дүрмийг ямар нэгэн тайлбаргүй өөрчлөх; эсвэл агуулахад хадгалалгүй шууд хүргэж өгөх
Улаан буудайг хувийн компаниудад өрсөлдөөнт тендэрээр зарах	Улаан буудайг худалдан авагч компаниудад ашигтайгаар, зах зээлийн үнээс доогуур борлуулах эрсдэл	БАГА: Үнийн доод түвшинг хангасан санал ирүүлээгүй бол Удирдах зөвлөлөөр үнийг тогтоож байсан <i>Эх үүсвэр: Мерси Корын тайлан</i>			Борлуулалтын үнийг зах зээлийн үнэтэй харьцуулах
Улаан буудайн ашиглалт	Экспортын бараанд ашиглах г.м. гэрээнд хориглосон зориулалтаар улаан буудайг ашиглах эрсдэл	ДУНД: Улаан буудайн борлуулалт гурил үйлдвэрлэгч компаниудаар хязгаарлагдаагүй бөгөөд улаан буудайг архи хийхэд ашиглаж, архийг нь экспортолсон байж болзошгүй			Худалдан авагчдад зарсан улаан буудайг хэрхэн ашигласныг шалгах

Борлуулалтын орлогыг банкинд хүлээж авах	Улаан буудайн борлуулалтын орлогыг дутуу бүртгэх буюу банкинд байршуулахаас өмнө хулгайлах эрсдэл	ДУНД: Улаан буудайн борлуулалтын хөтөлбөрийн менежерийн авилгалын хэргийг Мерси Кор тайландаа тэмдэглэсэн байсан <i>Эх үүсвэр: Мерси Корын тайлан</i>	Хяналтыг шалгаж, нэгээс олон хүн мөнгөтэй харьцаж, банкны гүйлгээ хийж байгааг баталгаажуулах
Улаан буудайн борлуулалтын орлогыг банкинд байршуулах	Улаан буудайн орлогыг зохистой хүү бүхий дансанд байршуулахгүй байх эрсдэл	БАГА: Улаан буудайн орлогыг хүүтэй дансанд байршуулсан <i>Эх үүсвэр: Мерси Корын тайлан</i>	Банкны хуулгыг хянах
Улаан буудайн борлуулалтын орлогыг хөгжлийн төслүүдэд ашиглах	Улаан буудайн борлуулалтаас олсон мөнгийг гэрээнд тусгагдаагүй зүйлд ашиглах эрсдэл	ИХ: Улаан буудайн борлуулалтын орлогыг гэрээнд зааснаас өөрөөр буюу зээл олгоход ашигласныг ҮАГ илрүүлсэн	Улаан буудайн борлуулалтын орлогоор юу хийснийг шалгаж, гэрээний дагуу зарцуулсан эсэхийг магадлах
	Улаан буудайн орлогоос хөгжлийн төсөлд өгөх мөнгө саатах эрсдэл	ДУНД: Улаан буудайн төслийн Удирдах зөвлөлийн зарим гишүүд банкны шилжүүлгийн баримтад гарын үсэг зурах гэж удсанаас 2000, 2002 оны санхүүжилт ихээхэн саатсан* <i>Эх үүсвэр: Мерси Корын тайлан</i>	Хөгжлийн төслүүдэд олгогдохоос өмнө борлуулалтын орлого хэр удаан саатсаныг шалгаж, гэрээнд заасан хугацаатай харьцуулах Саатлын шалтгааныг тодорхойлж, зохистой бол горимыг сайжруулах
	Хөгжлийн төслийн хэрэгжүүлэгч нар улаан буудайн мөнгийг буруу зүйлд зарцуулах эрсдэл	Төслийн мэдээлэл байхгүй боловч эрсдэл ИХ байж болзошгүй	Хөгжлийн төслүүдэд хуваарилсан бүх мөнгө гэрээнд заасан нөхцөлийн дагуу хөгжлийн төсөлд зарцуулагдсан эсэхийг шалгах
	Хөгжлийн төсөлд хамрагдагсад түүнийг хувийн ашиг сонирхолд зүй бусаар хэрэглэх эрсдэл		Хөгжлийн төслийн үр дүн болон төсөлд хамрагдагсад мөнгийг зохих ёсоор ашигласныг шалгах

*Тэмдэглэл: * Өмнөх онд улаан буудайн борлуулалтын хөтөлбөрийн менежер авилгалын хэрэгт холбогдсон учир 2002 онд АНУ-ын Элчин сайд 3 сая ам. долларын санхүүжилтийг хойшлуулсан. – Эх үүсвэр: Мерси Корын 2002 оны тайлан*

2.14. Хэрэв Засгийн газар залилангийн эсрэг хяналт тавьж байсан бол энэ бүлгийн 2.11-д дурдсан зүй бус үйл ажиллагааг урьдчилан сэргийлэх боломжтой байсан.

Залилангийн талаархи олон нийтийн санаа бодолд яамд соргог хандах хэрэгтэй

2.15. Сүүлийн үед сонин хэвлэлд улаан буудайн төсөл монголчуудад үр өгөөж өгч байгаа эсэх болон залилан, зүй бус ашиглалын эрсдэлийн талаар хэд хэдэн нийтлэл гарсан. Улаан буудайн төслийн талаар иргэд, хэвлэл мэдээллийнхний хөндсөн зүйлд

хариу өгөх үүднээс хариуцсан яам нь (одоо Сангийн яам хариуцаж байгаа) шалгалт хийж үнэн эсэхийг нь нягтлаад Улсын Их Хуралд болон олон нийтэд албан ёсоор танилцуулах нь зүйтэй байсан.

Залилангийн эрсдэлийг удирдахын тулд яамд зохих арга хэмжээ авах хэрэгтэй

2.16. Засгийн газрын олон үйл ажиллагаа залилангийн эрсдэлд өртөмтгий байдаг. Тиймээс яамд залилангийн эрсдэлийг тодорхойлж үнэлэх зохистой горим нэвтрүүлж, залилангийн эрсдэлийг их гэж үнэлсэн тохиолдолд залиланг урьдчилан сэргийлэх, илрүүлэх горим журам нэвтрүүлэх шаардлагатай. Яамд стратегийн төлөвлөгөөнийхөө нэг хэсэг болгож залилантай тэмцэх стратегийг боловсруулан, залиланг урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаж өгөх хэрэгтэй.

2.17. Хараат бус дотоод аудит гэх мэт байнгын дотоод хяналт ч олон төрлийн залиланг таслан зогсоож, илрүүлэх боломжтой.

2.18. Яам агентлагууд залилангийн эрсдэлийг удирдах зохистой арга хэмжээ авч, залилантай тэмцэх тогтолцоо, горим журам хэр үр нөлөөтэй байгааг тайлагнах үүргийг ахлах тушаалын аль нэг ажилтанд хариуцуулах хэрэгтэй. Дараахь хүснэгтийг ашиглан эрсдэлийн үнэлгээг баримтжуулж болно. Эрсдэл бүрийг тусдаа мөрөнд бичнэ.

Эрсдэлийн тодорхойлолт	Эрсдэлийг удирдах хүн	Эрсдэлийн түвшин – Их/ Дунд/ Бага	Эрсдэлийг удирдах буюу багасгахад шаардагдах арга хэмжээ	Арга хэмжээг хэрэгжүүлэх хүн	Эрсдэлийн үнэлээг хянасан огноо

Залилан үйлдсэн байж болзошгүй шинж тэмдэг байвал ахлах тушаалын ажилтан залиланг илрүүлэх, мөрдөн шалгах арга хэмжээг эхлүүлэх үүрэг хүлээсэн байвал зохино.

Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна:

Сангийн сайд Н.Баяртсайханд:

- Хас банкинд хөрөнгө оруулалт хийсэн 774,0 сая төгрөгийг Мерси Короос хүүгийн хамт авч 2000 оны хэлэлцээрт заасан төслүүдэд зарцуулах;
- Зээлийн баталгааны хөтөлбөрт зориулан банкуудад байршуулсан 591,2 сая төгрөгийг зээл эргэн төлөгдөх үед эргүүлж авах;
- Улаан буудайн тусламж хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа эсэхийг нягтлахын тулд 2000, 2002, 2003 оны хэлэлцээрээр санхүүжигдсэн бөгөөд одоо үргэлжлэн хэрэгжиж буй төслүүдийн явц, үр дүнг хянах тогтолцоо, горим бүрдүүлэх;
- 2002 оны улаан буудайн борлуулалтын орлогоос ГБЭЗХС хөтөлбөрийн тав дахь жилийн үйл ажиллагаанд зарцуулсан 3,157,026,202 төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг хөгжлийн төслүүдэд нөхөн олгохыг АНУ-ын Засгийн газраас хүсэх.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболдод:

- Улаан буудайн тусламжийн төслийн сургамжид үндэслэн залилангийн эрсдэлийг үнэлэх, залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга зүй боловсруулж яамдад хэрэгжүүлэх.

Сангийн яамнаас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2006.10.26 № 6-8/4496
танай 2006.10.13 -ны № 1/374 -Т

Тайланд санал өгөх тухай

АНУ-ын улаан буудайн буцалтгүй тусламжийн ашиглалт, зарцуулалтад хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Тусламжийн улаан буудайг хүлээн авах, борлуулах, борлуулалтын орлогоор хөгжлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх байгууллагыг АНУ-ын Засгийн газраас сонгон шалгаруулсаны дараа тус яам хөтөлбөрийн удирдах зөвлөл дэх өөрийн төлөөллөөр дамжуулан тусламжийн орлогын зориулалтын талаар шийдвэр гаргаж ирсэн билээ.

Улаан буудайн тусламжийн ашиглалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдад танилцуулж, тайланд дурдагдсан алдаа зөрчлийг АНУ-ын ЭСЯ-тай хамтран нягтлан шалгаж, тэдгээрийг арилгах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна. Зөрчлийг арилгах болон цаашид зөрчил гарах эрсдлийг бууруулах тодорхой арга хэмжээний талаар АНУ-ын ЭСЯ-тай зөвшилцсөний дараа энэ талаар Танд дахин мэдэгдэх болно.

Бидний ажилд туслалцаа үзүүлж байгаад талархал илэрхийлье.



Н.БАЯРТСАЙХАН

08 3644

Гадаад хэргийн яамнаас ирүүлсэн санал:



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН ЯАМ

210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7А, Утас: 26-21-35, Факс: 32-21-27
E-mail: mongmer@magicnet.mn
http://www.mongolia-foreign-policy.net

2006.10.25 № 04/4420
танай 2006.10.16 -ны № 1/374 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Л. ЖАВЗМАА ТАНАА

1/374 тоотын хариу

АНУ-н тусламжийн улаан буудайн ашиглалт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Манай улсын хувьд бусад улс, олон улсын байгууллагуудаас үзүүлж байгаа тусламжийн ашиглалтыг сайжруулах нь тулгамдсан зорилт билээ. Тиймээс ч эл зорилтод хүрэх нэг чухал хөшүүрэг болох аудитын шалгалтыг АНУ-ын тусламжийн улаан буудайн ашиглалт, зарцуулалтад хийсэн нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ болжээ гэж үзэж байна.

АНУ-ын улаан буудайн тусламжийг хоёр талын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу ашиглаагүй, хэлэлцээр зохих ёсоор хэрэгжээгүй, тусламжийн хөрөнгө мөнгийг зальхай этгээдүүд ашигласан нь тайланд тусгалаа олжээ.

Тайланд ГХЯ АНУ-ын талтай байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавиагүй орхигдуулсныг тэмдэглэжээ. Энэ нь тухайн үед тус яаманд гадаад хяналтын туршлага, тогтолцоо байгаагүйгээс үүрэг хүлээсэн газарт найдаж орхигдуулсантай холбоотой байна. Цаашид ийм байдлыг давтан гаргуулахгүйн тулд анхаарч ажиллах болно.

Хас банкинд оруулсан хөрөнгө мөнгийг хүүгийн хамт буцаан авах, хэлэлцээрийн дагуу хэрэгжиж буй төслүүдийн үйл явц, үр дүнг хянах тогтолцоо, горим бүрдүүлэх, ГБЭЗХС хөтөлбөрт зарцуулсан санхүүжилтыг хөгжлийн төслүүдэд нөхөн олгохыг АНУ-ын талаас хүсэх, залилангийн эрсдэлийг үнэлэх, залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга зүй боловсруулах зэрэг тайланд гаргасан зөвлөмжүүдийг зөв зүйтэй гэж үзэж дэмжиж байна.

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнг АНУ-ын талд зохих хэлбэрээр танилцуулах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.



Х. БЭХБАТ

0084011

21

Мерси Кор-оос ирүүлсэн санал:



www.mercycorps.org.mn

Огноо: 2006 оны 10-р сарын 27

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр

Монгол улсын Ерөнхий аудитор
ноён Л. Жавзмаа танаа

АНУ-ын тусламжийн улаан буудайн ашиглалт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлд өгөх санал

Эрхэм хүндэт ноёнтон,

Мерси Кор байгууллага танайхаас ирүүлсэн АНУ-ын тусламжийн улаан буудайн
ашиглалт, зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийн хувийг 2006
оны 10-р сарын 16-нд хүлээн авч улмаар танилцсан бөгөөд тус тайлангийн талаарх
саналаа үүгээр хүргүүлж байна.

1) Улаан буудайн тусламжийн төслийн өнөөгийн байдал

Аудитын тайлангийн Бүлэг 1.5-т: "..... 2000, 2002, 2003 оны хэлэлцээрээр
нийлүүлсэн улаан буудайн борлуулалтын орлогоор санхүүжсэн хөгжлийн төслүүд одоо
ч үргэлжлэн хэрэгжиж байна" гэжээ.

Мерси Кор-ын тайлбар: 2000 оны хэлэлцээрээр нийлүүлсэн улаан буудайн
борлуулалтын орлогоор санхүүжсэн АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн
төслүүдийн дотроос зөвхөн "Цагаан Хувьсгал" сүүн бүтээгдэхүүний төсөл нь одоогоор
үргэлжлэн хэрэгжиж буй. 2002 оны хэлэлцээрээр нийлүүлсэн улаан буудайн
борлуулалтын орлогоор санхүүжсэн АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн
хөтөлбөр нь 2004 оны 9-р сарын 30-ний өдөр буюу АНУ-ын Хөдөө Аж Ахуйн
Департаментад хөтөлбөрийн төгсгөлийн тайлан №6-г өгснөөр хаагдсан болно. 2003
оны хэлэлцээрээр нийлүүлсэн улаан буудайн борлуулалтын орлогоор санхүүжсэн АНУ-
ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн хөтөлбөр нь 2006 оны 3-р сарын 31-ний өдөр буюу
АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад хөтөлбөрийн төгсгөлийн тайлан №6-г өгснөөр
хаагдсан болно.

2) Хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэхэд Монгол улсын Засгийн газарт туслах нь улаан буудайн төслийн зорилго байв

Аудитын тайлангийн Бүлэг 1.8-т: "Улаан буудайн төслийн зорилгыг олон нийтэд
сайтар мэдээлж байгаагүй бөгөөд энэ нь ч улаан буудайн төслийг хүнсний тусламжийн
хөтөлбөр мэтээр ойлгосон байсан, одоо ч тийм хүлээлт байгаа талаархи хэвлэлийн
нийтлэлээс харагдаж байна" гэжээ.

24 Peace Ave., Bayanzurkh District
Ulaanbaatar, Mongolia
(+976.11) 46.11.45 tel
(+976.11) 46.10.48 fax
postmaster@mercyorg.org.mn

3015 SW First Avenue17
Portland, OR 97201
503.796.6800 tel
503.796.6844 fax

Claremont Crescent
Edinburgh
Scotland, UK EH7 4HX
+44.131.558.8244 tel
+44.131.558.8288 fax

**ҮАГ-ын тайлбар
1-ийг үзнэ үү.**

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

ҮАГ-ын тайлбар 2-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Мерси Кор 2000 оны хэлэлцээрээр нийлүүлсэн улаан буудайн борлуулалтын орлогоор санхүүжсэн АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн хөтөлбөр болох Хөдөөгийн Агробизнесийг Дэмжих Хөтөлбөрийн талаар түүнийг хэрэгжиж эхэлсэн цагаас нь хойш буюу 2004 оны 5-р сараас эхлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон тусгай материал бэлтгэж тараах замаар олон нийтэд өргөнөөр мэдээлж байсан. Эдгээр сурталчилгааны үйл ажиллагаа нь хөтөлбөрийн донор байгууллага болох АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн нэрийн дор явагдаж байсан болно.

3) Улаан буудайн үнэ өндөр тогтоогдсон, гэхдээ үнэлсэн арга нь төслийн зорилт, тусламжийн гэрээтэй нийцэж байна

Аудитын тайлангийн Бүлэг 1.11-т: "2000 оны борлуулах үнийг хэрхэн тооцоолсныг хэлэхээс Мерси Кор татгалзсан" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 3-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Мерси Кор энэхүү мэдээллийг хэлэхээс татгалзаагүй, дээрх гурван удаагийн хэлэлцээрээр санхүүжигдсэн АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн хөтөлбөрүүдтэй холбоотой бүхий л мэдээллийг аудиторудад гаргаж өгсөн. Манай Мерси Кор-ын ажилтнууд 2002, 2003 оны хэлэлцээрээр санхүүжигдсэн АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн хөтөлбөрүүдийн улаан буудайн борлуулалтын үнийг хэрхэн тооцоолж тогтоосныг сайн мэдэж буй боловч 2000 оны хэлэлцээрийн борлуулалтын үнийн хувьд арай бага мэдлэгтэй байж магадгүй. Хэдийгээр тийм ч гэсэн Монгол улсын Хөдөө Аж Ахуйн Яам ба гурил үйлдвэрлэгч компаниудтай хэлэлцэх, дотоод ба гадаадын зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа хийх замаар буюу дараахь хөтөлбөрүүдийн нэгэн адил улаан буудайн борлуулах үнийг тогтоосон гэдэгт бид итгэлтэй байна. Хамгийн гол нь борлуулах үнийг Удирдах Зөвлөлөөр албан ёсоор зөвшөөрүүлж батлуулсан явдал юм.

4) Улаан буудайн борлуулалтыг хэлэлцээрийн дагуу удирдаж байсан ч эрсдэл арилаагүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 1.14-т: "Улаан буудайг гурил үйлдвэрлэгч компаниудад гол төлөв борлуулсан боловч гурил үйлдвэрлэдэггүй компанид зарсан, уг улаан буудайг архи хийхэд ашигласан байж болзошгүй юм. Хэлэлцээрээр улаан буудайг дахин борлуулах буюу экспортлох, аль эсвэл дотоодынхоос өөр зориулалтаар ашиглахыг хориглосон. Гэтэл Мерси Кор ч, Монгол улсын Засгийн газар ч тусламжийн улаан буудайгаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлохоос сэргийлэх шалгалт хийсэн гэх нотлох зүйл бидэнд олдоогүй бөгөөд хэрэв улаан буудайг дахин борлуулж, түүгээр согтууруулах ундаа үйлдвэрлэсэн бол тэдгээрийг экспортлосон байж болох эрсдэл бий" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 4-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: АНУ-ын Засгийн газар болон Монгол улсын Засгийн газрын хооронд байгуулсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тусламж үзүүлэх тухай хэлэлцээрийн Зүйл IV. "Экспортын Хязгаарлалт"-д:

- а) Энэхүү хэлэлцээрээр хандивласан бүтээгдэхүүнийг экспортлосон АНУ-ын санхүүгийн жил буюу удаахь санхүүгийн жилийг экспортын хязгаарлалтын хугацаа гэж үзнэ.
- б) Хэсэг I, Параграф E93-ын зориулалтаар, экспортлож болохгүй бараа бүтээгдэхүүний тоонд улаан буудай, улаан буудайн гурил, хавтгайлсан улаан буудай, хүүхдийн будаа, цардуул буюу төмсний гурил (буюу өөрөөр нэрлэсэн ижил бараа бүтээгдэхүүн) зэрэг орж болно.

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

Дээрх заалтаар архи, согтууруулах ундааг хамраагүй. Статистикийн тоо мэдээгээр Монголоос экспортлосон архи, согтууруулах ундааны хэмжээ нь дотооддоо үйлдвэрлэж хэрэглэсэн нийт хэмжээний дөнгөж 0.02-0.45%-ийг л эзэлж байна. Иймд, тусламжийн улаан буудайгаар архи үйлдвэрлэж түүнийг экспортлосон байх магадлал тун бага байна.

Монгол улсын Үндэсний Статистикийн Газрын архи, согтууруулах ундааны үйлдвэрлэл ба экспортын хэмжээний тоо мэдээгээр бол:

2001 онд: 8.626.500 литр архи үйлдвэрлэж түүнээс 1400 литрыг экспортлосон (0.02%)

2002 онд: 9.436.200 литр архи үйлдвэрлэж түүнээс 19800 литрыг экспортлосон (0.20%)

2003 онд: 8.873.100 литр архи үйлдвэрлэж түүнээс 21300 литрыг экспортлосон (0.24%)

2004 онд: 9.161.000 литр архи үйлдвэрлэж түүнээс 40800 литрыг экспортлосон (0.45%)

5) Хөгжлийн төслүүдийн ашиг тусыг олон иргэд хүртсэн

Аудитын тайлангийн Бүлэг 1.21-т: "2000 он Сүүн ферм ажиллуулахын тулд борлуулалтын орлогоос Шинэ Зеландын бизнес эрхлэгчийг дэмжсэнийг аудитаар илрүүлсэн. Зээлээ эргэн төлмөгц бизнес эрхлэгчийн өмчид шилжих үхэр, бусад хөрөнгө худалдан авахын тулд Мерси Корын батлан даалтаар Хас банкнаас авсан зээлээр энэ бизнес санхүүжжээ" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 5-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Тодруулга өгөх нь: "Алпайн" ХХК нь үхэр болон бусад "хөдлөх" хөрөнгө худалдаж авахын тулд Мерси Кор-оос гаргасан баталгаатайгаар Хас банкнаас арилжааны зээл авсан. Дэд бүтцийн хөрөнгө оруулалтууд (үнээний байр, хашаа, байшин ба худаг)-ыг төслийн хөрөнгөнөөс санхүүжүүлсэн бөгөөд төсөл хэрэгжиж дуусмагц сумын засаг захиргааны өмчид шилжих болно.

Аудитын тайлангийн Бүлэг 1.21-т: "2000 он Мерси Кор уг төслийн хэрэгжүүлэгчээр Шинэ Зеландын хөрөнгө оруулалттай "Алпайн" ХХК-ийг тендергүй сонгосон бөгөөд үүнийгээ "сүүний ферм үүсгэн байгуулах, удирдах чадвартай, Монголд цорын ганц дадлага туршлага бүхий хүн удирдаж буй "Алпайн" ХХК-ийг сонгосон" гэж тайлбарласан ч аудитын явцад энэ давуу тал ажиглагдсангүй" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 6-г үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Юуны түрүүнд "Алпайн" ХХК нь Шинэ Зеландын хөрөнгө оруулалттай Монголын компани мөн тул энэ чухал ялгааг тодотгох нь зүйтэй болов уу. Сүүний үйлдвэрлэл явуулах тодорхой сонирхол илэрхийлж байсан өөр цорын ганц компани нь санхүүжилтийг тэтгэлгийн хэлбэрээр олгохгүй гэдгийг мэдмэгц цаашид өрсөлдөхөө больсон.

Аудитын тайлангийн Бүлэг 1.21-т: "2000 он АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад өгсөн Мерси Корын 2000 оны тайланд "Үйл ажиллагаа нь сайжирч буй суун фермийн менежмент, үр дүнг ажиглахад ойр хавийн зарим малчид худалдан авалт, хангалттай нэмэлт тэжээл бэлтгэх зэрэг шилдэг туршлагаас нь нэвтрүүлжээ", "орон нутгийн ажилтнуудад байшин барьсан", "2005 оны 8, 9 сард 60 үнээнээс 7200 литр сүү сааж анхны борлуулалт хийсэн" гэж бичсэн хэдий ч малчдыг өргөнөөр оролцуулсан ямар нэгэн албан ёсны сургалт хийгээгүй, байшин бариагүй, сүү борлуулах баримт, саалийн хэрэгсэл байхгүй, үнээний ашиг шим нь муу байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 7-г үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Мерси Кор дараахь зүйлийг "Алпайн" ХХК-иас тодруулсан болно:

- (а) "Үйл ажиллагаа нь сайжирч буй суун фермийн менежмент, үр дүнг ажиглахад ойр хавийн зарим малчид худалдан авалт, хангалттай нэмэлт тэжээл бэлтгэх зэрэг шилдэг туршлагаас нь нэвтрүүлжээ" - ойр хавийн дор хаяхад 12 малчин

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

- өрх / жижиг фермүүд худалдан авалт, хангалттай нэмэлт өвс тэжээл бэлтгэх хадгалах зэрэг "Алпайн" фермийн шилдэг туршлагаас нэвтрүүлэв.
- (б) "Орон нутгийн ажилтнуудад байшин барьсан" - Мерси Кор-оос ад өгсөн тайланд "орон нутгийн ажилтнуудыг орон байраар хангасан" гэж дурдсан. Гэр нь монголчуудын уламжлалт амьдрал ахуйд нийцсэнээр барахгүй, тухайн төслийн байршил ба нөхцөл байдалд нэн тохирсон орон байр байсан учраас орон нутгийн ажилтнуудад монгол гэр худалдан авч фермд барьж өгсөн.
 - (в) "2005 оны 8, 9-р сард үнээнээс 7200 литр сүү сааж анхны борлуулалт хийсэн" - 2005 оны 8, 9-р сард 50 үнээнээс өдөрт 120 литр авч байсан. Эдгээр үнээ нь бүгд эм бяруу байсан тул сүүний гарц өндөр байгаагүй. Түүнчлэн, үнээнүүд тугалласан учраас өдөрт нэг л удаа сааж үлдсэнийг нь тугалд нь үлдээж байсан. Фермийн зорилго нь сүүний чиглэлийн сүрэг бүрдүүлэхэд оршиж байсан тул бүх үнээгээ хээлтүүлгэнд оруулж байсан. Иймд тухай үед нэг тугал эхээсээ дунджаар 4,5 литр хөхөж, үйлдсэн сүүг нь борлуулж байсан тул борлуулах сүүний хэмжээ нь харьцангуй бага байсан.
 - (г) Сүүгээ Улаанбаатар дахь "Сүү" компанийн үйлдвэрт борлуулж Дархан - Улаанбаатар автозамаар аялдаг сүүний машинд тушааж гараар үйлдсэн бичгэн баримт авдаг байсан.
 - (д) Тус төслийн зорилтуудын нэг нь саалийн хэрэгсэлтэй болгох бус харин сонирхож буй бусад малчдад тэргүүн туршлагыг нь аж ахуйдаа нэвтрүүлж болохуйц, сүүний чиглэлийн үхрийг өсгөн бойжуулах арга технологийг нэвтрүүлсэн үлгэр шижээч сүүний ферм байгуулахад оршиж байсан. Саалийн хэрэгсэл нь цахилгаан хангамж, тусгай нарийн багаж төхөөрөмж болон мэргэжлийн засвар үйлчилгээ шаарддаг. Сулхан дэд бүтэцтэй, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл ба мэргэжлийн засварчдын олдоц муутай Монголын хөдөө орон нутгийн сүүн фермүүдийн хувьд саалийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийх нь эдийн засгийн үүднээс үр ашиггүй юм.

Аудитын тайлангийн Бүлэг 1.21-т: "2000 он Хугацаа хойшилсноос төслийн хэрэгжилт одоо ч эхлэл төдий байна. Хэрэв төсөлд малчдыг илүү өргөн хамруулж сургалт зохион байгуулахгүй бол төсөл дуусахад Шинэ Зеландын нэг иргэн 500 үнээтэй болж, цөөн хэдэн молголчуудыг хөлслөн, улаан буудайн борлуулалтын орлогын 625,8 сая төгрөгөөр ашигтай бизнес хийсэн гэсэн гол үр дүн гарах эрсдэл байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 8-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Шинэ Зеландын иргэн улаан буудайн борлуулалтын орлогын 625,8 сая төгрөгөөр ашигтай бизнес хийсэн гэдэг нь үнэнд үл нийцэх болов уу. "Алпайн" ХХК гэдэг Монголын компанид, 2006 оны 9-р сарын 30-ны байдлаар, 149,0 сая төгрөгийн л төлбөр хийгдсэн. 50,0 сая төгрөг нь тухайн газрын дэд бүтцийг байгуулахад зарцуулагдсан тул газрыг нь эзэмшиж буй сумын засаг захиргаанд үр ашигтай, тустай зүйл болсон. 198,2 сая төгрөгийг банкны зээлийн барьцаанд зарцуулсан бөгөөд энэ хөрөнгийг "Алпайн" компанид өгөхгүй. Мөн 2006 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаар гэхэд бүгд 319,7 сая төгрөг (хүүг оруулан) зарцуулагдаагүй хэвээр буй. Иймд, дээр дурдсан хэмжээнээс зөвхөн 130,0 сая орчим төгрөгийг л "Алпайн" ашигласан байж болзошгүй гэсэн дүгнэлт гарч байна.

Монгол улсын Хөдөө Аж Ахуйн Яам уг төслийг санхүүжилтийн шалгууруудад нийцүүлэх хэмжээнд боловсруулж чадахгүй байна гэдэг нь АНУ-ын ЭСЯ-нд тодорхой болмогц төслийг Мерси Кор-т шилжүүлсэн. АНУ-ын ЭСЯ-ны эдийн засгийн зөвлөх 2003 оны 8-р сард уг төслийг баталж зөвшөөрсөн бөгөөд төслийн санхүүжилтийг Мерси Кор 2003 оны 9-р сард авсан. Иймээс төсөл одоогоор хэрэгжилтийнхээ хуваариас хоцорч буй боловч санал болгосон сургалтын үйл ажиллагаа нь төлөвлөгөөний томоохон хэсгийг эзэлсэн хэвээр байгаа.

Аудитын тайлангийн Бүлэг 1.21-т: "2002 он Төсөлд хамрагдсан хүмүүсийн тоо 2002 оны хэлэлцээрт тусгагдсан түвшний 30 орчим хувь байгаа нь ихээхэн доогуур үзүүлэлт юм. Гэхдээ Гадаад Харилцааны Яам 2002 оны төслүүдийг хэрхэн хэрэгжүүлэх

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

ҮАГ-ын тайлбар 9-ийг үзнэ үү.

талаар Мерси Кор-т чиглэл өгсөн бөгөөд тэрхүү чиглэл нь 2002 оны хэлэлцээрт заасан төсөлд хамрагдах хүмүүсийн тооноос зөрүүтэй байжээ" гэжээ.

Мерси Кор-ын тайлбар: 2002 оны АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаменттай байгуулсан хэлэлцээрт тусгагдсан төслийн үр ашиг хүртэгчид (буюу төсөлд хамрагдсан хүмүүс)-ийн тоог АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад тайлагнасан төслийн гүйцэтгэлтэй харьцуулвал:

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд	Зорилго	Гүйцэтгэл	Хувь
Мал аж ахуйн менежмент	6000 малчин өрх	1892 малчин	32%
Бэлчээрийн нөөцийн менежмент	600 малчин өрх	946 малчны бүлэг	157%
Усны нөөцийн менежмент	400 малчны бүлэг	120 малчин өрх	ү/х
Үйлдвэрлэлийг дэмжих	500 хоршоо/бизнес	1625 хоршоо/бизнес	325%

Аудитын дүн нь төслийн дөрвөн бүрэлдэхүүн хэсгийн зөвхөн хоёрт нь хамааралтай байна. Бэлчээрийн нөөцийн менежмент болон үйлдвэрлэлийг дэмжих дэд төслүүдийн хувьд төсөлд хамруулах хүмүүсийн зорилтот тоог ихээхэн давуулсан. Нэгэнт бусад донор байгууллагын санхүүжүүлж буй болон Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй олон төсөл хөтөлбөрүүд мал аж ахуй, бэлчээрийн болон усны нөөцийн менежментийг боловсронгуй болгох тал дээр ажиллаж буй тул нөхцөл байдлыг бодитой үнэлсний үндсэн дээр Мерси Кор үйлдвэрлэлийг дэмжих дэд төслийг түлхүү хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. Чиглэлээ ийнхүү өөрчилсөн нь Монгол улсын Засгийн газар 2003 оныг Хоршооны Жил хэмээн зарласантай мөн холбоотой. Гол төлөв малчдаас бүрдсэн төслийн 1300 гаруй үйлчлүүлэгчид хоршооны сургалтанд хамрагдсаны үр дүнд 62 шинэ хоршоо үүсэн байгуулагдсан билээ.

Аудитын тайлангийн Бүлэг 1.21-т: "2003 он Төсөлд хамрагдсан хүмүүсийн тоо зорилтот түвшинтэй харьцуулахад ихэвчлэн доогуур байсан. Гэхдээ Гадаад Харилцааны Яам 2003 оны төслүүдийг хэрхэн хэрэгжүүлэх талаар Мерси Кор-т чиглэл өгсөн бөгөөд тэрхүү чиглэл нь 2003 оны хэлэлцээрт заасан төсөлд хамрагдах хүмүүсийн тооноос зөрүүтэй байжээ" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 10-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: 2003 оны АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаменттай байгуулсан хэлэлцээрт төслөөс үр ашиг хүртэх (буюу төсөлд хамруулах) хүмүүсийн тоог ингэж заасан байна:

Төслийн бүрэлдэхүүн хэсэг	Зорилго
Сургалт, зөвлөгөө	50000 хүн
Хөдөөгийн Бизнес Мэдээ	70000 хүн
Хөдөө аж ахуйн сэдэвт радио нэвтрүүлэг	350000 хүн

Мерси Кор-оос 2003 онд АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад өгч Удирдах Зөвлөлөөр албан ёсоор зөвшөөрүүлсэн саналд сургалт зөвлөгөөнд хамруулах хүмүүсийн тоог өөрчилж детальчилсан. Зорилтот ба бодит хэмжээг дор харуулав:

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд	Зорилго	Гүйцэтгэл	Хувь
Малчдад зориулсан сургалт, техникийн туслалцаа	1600 хүн	7690 хүн	480%
Бизнес Хөгжлийн Үйлчилгээ үзүүлэгчийн чадавхийг бий болгох	5 холбоод	1 холбоо, орон нутгийн 144 сургагч багш	
Бизнесийн сургалт, техникийн туслалцаа	10 бизнес / 100 ажилтан	2740 хүн	2740%
Бизнес төлөвлөлт	10 бизнес / 50 ажилтан	116 бизнес	1160%
Бизнесийн санхүүжилт (баталгаа)	80 малчны бүлэг/бизнес	264 бүлэг/бизнес	330%
Малын эмч, зоотехникчдэд зориулсан сургалт	90 малын эмч/ зоотехникч	284 малын эмч/ зоотехникч	315%

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

Малын тэжээллэгийн сургалт	6 малчны бүлэг	Туршилтын 1 малчны бүлэг	17%
Сүү, цагаан идээний аюулгүй байдлын сургалт	15 малчны бүлэг	16 малчны бүлэг	107%

Дээрх хүснэгтээс харахад ганцхан тохиолдолд букуу малын хоол тэжээллэгийн хяналт мониторинг ба сургалтын хувьд гүйцэтгэл нь зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд энэ нь тус дэд төслийн бүрдэл хэсэг (малын баасын шинжилгээ)-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байсан технологийг нэвтрүүлэхэд хүндрэл саатал учирсантай холбоотой.

Түүнчлэн, сүү, цагаан идээний хүнсний аюулгүй байдлын аян нь сонин сэтгүүл, хэвлэлийн материал, радио телевизээр дамжуулан сүү, цагаан идээний 600000 үйлдвэрлэгчид ба хэрэглэгчдийг хамарсан гэсэн тооцоо байдаг.

Хөдөөгийн Бизнес Мэдээ сэтгүүлийн уншигчид, хөдөө аж ахуйн сэдэвт радио телевизийн сонсогч, үзэгчдийн тоог дор үзүүлсэн болно:

Төслийн бүрэлдэхүүн хэсэг	Зорилго	Гүйцэтгэл	Хувь
Хөдөөгийн Бизнес Мэдээ	70000 хүртэгсэд	485317 уншигч, сонсогч ба үзэгч	693%
Хөдөө аж ахуйн сэдэвт радио нэвтрүүлэг	100000 хүртэгсэд 350 000	103105 радио сонсогч	103%

Аудитын тайлангийн Бүлэг 1.21-т: "2003 он АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад өгсөн Мерси Кор-ын 2003 оны тайланд Си-Эйч-Эф-ийн хэрэгжүүлсэн зарим дэд төслийн санхүүжилт, үр дүн бичигдээгүй байлаа. Тухайлбал:

- Бий болгосон ажлын байр ба ажилд оруулсан хүн
- Жижиг бизнесийг өргөжүүлсэн ба сайжруулсан үзүүлэлт
- Шинээр эхлүүлсэн жижиг бизнес' гэжээ.

ҮАГ-ын тайлбар 11-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Си-Эйч-Эф байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг Мерси Кор тайлагнах хариуцлага хүлээгээгүй. Си-Эйч-Эф нь Удирдах Зөвлөлд өөрийн бичсэн тайлангуудаа өгч байсан.

6) Хөгжлийн зарим төслийн санхүүжилт саатаж байжээ

Аудитын тайлангийн Бүлэг 1.22-т: "2003 онд АНУ-ын ЭСЯ төслийн тендер зарласан боловч шаардлага хангасан санал ирээгүйгээс Си-Эйч-Эф хэмээх сайн дурын байгууллагад уг ажилд зориулсан мөнгийг тендергүй олгожээ. Гэтэл энэ мөнгийг зам сайжруулах ажилд ашиглалгүй, гэр хорооллын жижиг, дунд бизнес хөгжлийн төсөлд зарцуулжээ. Бид энэ төсөлд аудит хийгээгүй" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 12-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Тусламжийн хэлэлцээрийн нөхцөл заалтуудаас харахад эдгээр хөрөнгө санхүүжилтийг олгоход Мерси Кор ямар ч үүрэггүй байсан нь тодорхой байна.

7) 2000 оны зарим санхүүжилт хэлэлцээрийн дагуу хийгдээгүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 1.24-т: "Мерси Кор 2000 оны хэлэлцээрийн дагуу малын менежмент, усны үйлчилгээ, худаг засварын ажлыг санхүүжүүлээгүй болох нь аудитаар тогтоогдлоо. АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад өгсөн тайландаа Мерси Кор "худагны сэргээн засварлалт, сургалтын үйл ажиллагааг дараа нь өөр хөтөлбөрөөр

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

санхүүжүүлсэн" гэжээ. Энэ нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын бусад хөтөлбөр ойролцоо үйл ажиллагаа явуулж байсан учир улаан буудайн борлуулалтын орлогыг 2000 оны хэлэлцээрт заасны дагуу ашиглахгүйгээр шийдсэн байж болох юм" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 13-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: 2000 оны АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн хөрөнгө санхүүжилт саатсаны улмаас Мерси Кор худгийн засварын ажил болон холбогдох сургалтын үйл ажиллагааг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаас авсан хөрөнгө санхүүжилтээр хэдийнэ хэрэгжүүлчихсэн байсан. 2000 оны хэлэлцээрийн Бүлэг Е, хэсэг 2, "Борлуулалтын Орлогын Ашиглалт"-д төвлөрүүлсэн хөрөнгийг бусад зүйлээс гадна "төрөлжүүлсэн сургалт явуулах болон зээл олгох үйл ажиллагаа"-нд зарцуулах тухай заасан тул улаан буудайн борлуулалтын орлогыг 2000 оны хэлэлцээрт заасны дагуу ашигласан болно.

Аудитын тайлангийн Бүлэг 1.25-т: "АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад өгсөн тайландаа Мерси Кор "өмнөх онуудад бүртгэгдсэн нийт 888.8 сая төгрөгийг Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачлага хөтөлбөрийн үйл ажиллагаа (114,8 сая төгрөг) болон Говийн Санаачлага төслийн хүрээнд "Говийн Эхлэл" жижиг зээлийн үйлчилгээг дэмжихэд (774,0 сая төгрөг) ашигласан" гэжээ. Энэхүү Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачлага хөтөлбөр нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын хөтөлбөр бөгөөд энэ нь үнэн хэрэгтээ мөнгийг 2000 оны хэлэлцээрт тусгагдаагүй Америкийн төсөлд шилжүүлсэн гэсэн үг юм. Дээрх 114,8 сая төгрөгийн 3,1 сая төгрөгийг Говийн Санаачлага хөтөлбөрийн ажилтнуудын цалинд ашиглаж, 111,7 сая төгрөгийг Мерси Кор-ын АНУ дахь төв аппарат руу шилжүүлснийг аудитаар илрүүллээ" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 14-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Уг хөрөнгийг хэзээ ч өөр төсөлд шилжүүлээгүй бөгөөд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын санхүүжилттэй Говийн Санаачлага хэмээх төслийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилгоор ашигласан болно. Мерси Кор-ын АНУ дахь төв аппарат руу шилжүүлсэн мөнгийг жижиг зээлийн үйлчилгээг дэмжих дэд төслийн шугамаар ирж ажилласан гадаадын техникийн зөвлөхийн ажлын хөлсөнд зарцуулсан.

Аудитын тайлангийн Бүлэг 1.26-т: "Ашгийн бус байгууллага болох Мерси Кор Говийн Санаачлагын хүрээнд "ашиг олох" банкны үйл ажиллагаанд хөрөнгө оруулжээ" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 15-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: 774,0 сая төгрөгийг Говийн Санаачлага хөтөлбөрийн хүрээнд Мерси Кор-оос санаачилсан жижиг зээлийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагаа явуулах "Говийн Эхлэл" төсөлд өгсөн. "Говийн Эхлэл" нь цаашдаа Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн "Микростарт" төсөлтэй нэгдсэнээр Хас банкыг үүсгэн байгуулсан.

Аудитын тайлангийн Бүлэг 1.27-т: "Дээрх 774.0 сая төгрөгийг Мерси Кор-ын санхүүгийн тайланд авлага болон урт хугацаат хөрөнгө оруулалтын аль ч хэлбэрээр тусгалгүй, шууд зардалд тайлагнасан нь буцааж авах ёстой мөнгө гэдгийг илэрхийлж чадахгүй байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 16-г үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Донор байгууллага болох АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад эдгээр хөрөнгө эргэж төлөгдөнө гэсэн хүлээлт байхгүй, харин Мерси Кор зээлийн үндсэн хөрөнгө, зээлийн баталгааны хөрөнгө г.м.-ийн боломжит ашиглалтын механизмын талаар тайлагнах нөхцөлтэйгээр эдгээр бүх хөрөнгийг зарцуулна гэж ойлгож буй. Мерси Кор нь Хас банкны хувьцаа эзэмших санаатай буйгаа АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад мэдэгдсэн. Банкны эрхэм зорилгыг хүлээн зөвшөөрсөн бусад хөрөнгө оруулагчид Мерси Кор-ыг орлон сольж түүний банк дахь орон зайг эзэлсэн цагт Мерси Кор эзэмшиж буй хувьцаануудаасаа салах болно. 2004 оны 6-р сард АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийг төлөөлөх АНУ-ын ЭСЯ ба АНУ-

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

ын Олон Улсын Хөгжлийн Агентлагад мэдэгдсэнээр, хувьцаагаа арилжаалж олсон хөрөнгийг АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментаас санхүүжсэн төслүүдийн зорилгод нийцэхүйц зориулалтаар ашиглана. АНУ-ын ЭСЯ-ны эдийн засгийн зөвлөх ноён Майк Лэйн ба АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын Филиппин улсын Манила хот дахь төлөөлөгчийн газрын гэрээний ажилтан ноён Вильям Рейнолдс-т хүргүүлсэн албан захидлын хуулбаруудыг хавсаргав.

Аудитын тайлангийн Бүлэг 1.29-т: "Хөрөнгө оруулалт хийсэн мөнгийг "шаардлагатай үед татан авч өөр төсөлд зарцуулна" гэж Мерси Кор-ын удирдлага хэлсэн. Гэтэл хэлэлцээрээр зорилт бүрийг санхүүжүүлэх хувийг тодорхой зааж өгч, нийт дүнг 100%-д тулгаж бариулаад байхад ийнхүү тайлбарлаж байгаа нь ойлгомжгүй байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 17-г үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: 2000 оны хэлэлцээрийн Бүлэг Е, хэсэг 2, "Борлуулалтын Орлогын Ашиглалт"-д төвлөрүүлсэн хөрөнгийг бусад зүйлээс гадна "төрөлжсөн сургалт явуулах болон зээл олгох үйл ажиллагаа"-нд зарцуулах тухай дурдсан. Тус хэлэлцээрээр зээл олголтын механизмыг детальчлаагүй болоод ямар нэгэн хязгаарлалт тавиагүй билээ. АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн 2003 оны хэлэлцээрт "..... агробизнесийн жижиг үйлдвэрлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь туслах зорилгоор зээлийн баталгаа гаргах" зөвшөөрлийг баталгаажуулсан тул АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент ба Удирдах Зөвлөл нь төвлөрсөн хөрөнгийг арилжааны банкуудаар дамжуулан ашиглаж зарцуулахыг хүлээн зөвшөөрсөн.

Ийм хэлбэрээр хөрөнгө ашиглахыг хориглоогүй учраас 2000 оны хэлэлцээрийг зөрчөөгүй гэж үзэж байна. Үүгээр барахгүйгээр, хөрөнгийн ашиглалтын талаар АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад тайлагнахад тэрээр төслийн хэрэгжсэн байдлыг зүйд нийцэхгүй байна гэж хэзээ ч дурдаж байгаагүй. Үнэн хэрэгтээ, хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцсан АНУ-ын Засгийн газрын олон өндөр албан тушаалтан АНУ-ын ЭСЯ-тай тохиролцсоноор хөдөө орон нутгийн иргэдэд жижиг зээл олгох болон орон нутгийг хөгжүүлэх цаашдын төслүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр бий болгох зорилгоор борлуулалтын орлогыг ашиглаж буй байдлыг "давхар үр ашигтай" хэмээн үнэлсэн байдаг.

Мерси Кор албан захидалдаа санал болгосон Хас банк дахь хувьцаагаа борлуулсны дараа хөрөнгийг нь хэрхэн ашиглах гэж буй талаар АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент хэзээ ч ямар нэгэн дургүйцэл юмуу эсэргүйцэл илэрхийлж байгаагүй.

8) 2002 оны улаан буудайн борлуулалтын орлогын 90 гаруй хувийг АНУ-ын ОУХА-ийн хөтөлбөрт ашиглажээ

Аудитын тайлангийн Бүлэг 1.30-т: "2002 оны улаан буудайн орлогын 90 гаруй хувь ба 3,0 тэрбум төгрөгийг Мерси Кор болон АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын хамтран хэрэгжүүлсэн Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачлага хөтөлбөрийн тав дахь жилийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашигласныг аудитаар илрүүллээ. Энэ санхүүжилтийг Гадаад Харилцааны Яам зөвшөөрсөн бөгөөд улаан буудайн төсөл, Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачлага хөтөлбөрийн зорилтын хооронд үл авцалдах зүйл үгүй. Гэхдээ улаан буудайн орлогыг хэлэлцээрт заасны дагуу хэрэглэж, Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачлага хөтөлбөрийг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бол монголын иргэд хоёр дахин илүү тусламж авах байжээ" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 18-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн санхүүжилт нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын санхүүжилтийг ОРЛОХ бус харин шаардлагатай хэмжээнд нь ХҮРГЭЖ, НЭМЭГДҮҮЛЭХ зориулалттайгаар ашиглагдсан.

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын нь эхний хэлэлцээрээр заасан албан ёсоор олгогдож болох дээд хэмжээ болох 10,0 сая ам. долларын 9,9 сая ам. долларыг Говийн Санаачлага хөтөлбөрийн 1-р үе шатыг санхүүжүүлэхэд гаргасан. АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент нь 2002 оны хэлэлцээрээр 2,7 сая ам. доллар буюу 3,15 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт хийснээр 1999 оны 1-р сараас 2004 оны 2-р сар хүртэлх хугацаанд говийн аймгуудад үзүүлсэн нийт тусламжийн хэмжээг 12,6 сая ам. долларт хүргэсэн.

Аудитын тайлангийн Бүлэг 1.31-т: "Монгол улсын Засгийн газар болон Мерси Кор-ын хооронд байгуулсан гэрээнд борлуулалтын орлогын 95 хувийг мал аж ахуйн менежмент, бэлчээрийн нөөцийн менежмент, усны нөөцийн менежмент, хувийн хэвшлийн менежментэд тэнцүү хуваан зарцуулахаар тусгажээ. Гэтэл 2002 оны борлуулалтын орлогын 95 хувь буюу Мерси Кор-ын зарцуулах хөрөнгөд 3070.5 сая төгрөг төвлөрч, үйл ажиллагааны буюу шууд бус зардалд 85 хувийг, үлдэх 15 хувийг хөтөлбөрийн зардалд зарцуулсан байна. Энэ нь Хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрийн 4 хэсэгт хувааж зарцуулах гэрээний заалтыг зөрчсөн байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 19-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Мерси Кор нь "үйл ажиллагаа" ба "хөтөлбөр"-ийн хооронд ямар нэгэн ялгаа буй гэж боддоггүй. "Үйл ажиллагаа" ч ялгаагүй "хөтөлбөр" юм. Мерси Кор-ын Монголд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд бизнесийн сургалт явуулах ба техникийн туслалцаа үзүүлэхэд түлхүү анхаардаг. Мерси Кор-ын ажилтнуудын 70 гаруй хувь нь хөтөлбөрийн үйлчлүүлэгчдэд шууд үйлчилгээ үзүүлдэг ба "үйл ажиллагаа"-ны зардлын ихэнхи хувийг эдгээр ажилтнуудын ажлыг дэмжихэд зарцуулдаг. Яг захиргааны зардалд 15%-ийн шууд бус зардал ордсг. Тэнцүү хувааж зарцуулна гэсэн заалт хэлэлцээрт байхгүй.

Аудитын тайлангийн Бүлэг 1.32-т: "41.9 мянган долларыг Мерси Кор-ын ажилтнуудын ажилгүйдлийн даатгалын санг 1999 оны 5 дугаар сараас байгуулаагүй байсныг нөхөн байгуулж зардалд бичсэн" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 20-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: 41,9 мянган ам. долларыг Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 3-р бүлгийн 42 дугаар зүйлийн 1-д зааснаар ажлаас халагдсаны тэтгэмжийн сан буюу ажилгүйдлийн даатгалын санг байгуулах зорилгоор зарцуулсан. Үйл ажиллагаагаа Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн заалтанд нийцүүлэх зорилгоор л энэхүү хуримтлалыг бий болгосон.

Жич - 1308,7 мянган ам. доллар юмуу 1308,7 мянган ам. долларын 56% нь дурдсан 4 зүйл зардлын нийлбэр (232,9 мянган ам. доллар)-тэй авцалдахгүй байна.

9) Бага хүүтэй зээл олгох нөхцөл бүрдүүлэх зорилт хэрэгжээгүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 1.33-т: "Зээлийн баталгааны хөтөлбөр 2003 оны борлуулалтын орлогоос 384,0 сая төгрөгөөр 11 банк ба банкны бус санхүүгийн байгууллагад 80 орчим зээлд зориулж баталгаа гаргах ба үүнд 11 хүртэлх аймгийн 64 бүлэг, хоршоо буюу 2560 хүн, 16 бизнес буюу 160 хүн хамруулахаар төлөвлөжээ. Энэ хөтөлбөрт зээлийн хугацааг уртасгах, хүүг багасгах, зээлдэгчдэд илүү ашигтай нөхцөл бүрдүүлэх зорилттой байсан ч банкуудтай байгуулсан гэрээнд нөхцөлүүд тухайлбал, зээлийн хүү бага байх заалт тусгагдаагүй байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 21-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Мерси Кор-ын банкуудтай байгуулсан гэрээнд зээлийн хүүг бууруулах тухай заалт байхгүй боловч банкуудтай бичгээр харилцсан баримт бичгүүдэд зээлийн хүүг бууруулах талаар хүсэлт тавьж байсан (банкуудад илгээсэн албан захидлуудын хуулбарыг хавсаргав). Үүний үр дүнд зээлийн хүү буурсан. Хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө малчдад олгож байсан зээлийн хүү сард 2,5%-аас 4,5%-ийн хооронд хэлбэлзэж байсан бол хөтөлбөр хэлснээс хойш сарын зээлийн хүү

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

1,5% болж буурсан. Мөн хөтөлбөр эхлэхээс өмнө зээлийн дундаж хугацаа 8 сар байсан бол одоо дунджаар 15 сар болоод байна.

Аудитын тайлангийн Бүлэг 1.34-т: "Монгол улсын Засгийн газар болон Мерси Кор-ын хооронодын гэрээгээр 2003 оны зээлийн баталгаа хөтөлбөр 2006 оны 1 дүгээр сард хугацаа дууссан тул нэмэлт барьцаа хэлбэрээр банкуудад байршуулсан 393,0 сая, "Алпайн" ХХК-ийн зээлийн барьцаанд байршуулсан 198.2 сая төгрөг, нийт 591.2 сая төгрөгийг Монгол улсын Засгийн газарт буцааж өгөх ёстой" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 22-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Хөрөнгийг Монгол улсын Засгийн газарт буцааж өгөх тухай заалт байхгүй. Удирдах Зөвлөлийн баталсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн Бүлэг 3. "Хөрөнгийн Ашиглалт"-д Мерси Кор улаан буудайн борлуулалтын орлогын 320,000 ам. долларыг арилжааны банкууд ба хадгаламж зээлийн хоршоодоос бизнес өргөжүүлэх 80 зээл авахад малчны бүлэг, хоршоонд дээд тал нь 3500 ам. доллар, томоохон бизнест 6000 ам. доллартай тэнцэх бэлэн мөнгөний нэмэлт барьцаа гаргахад зарцуулна гэжээ. Ийнхүү зээлийн баталгаа гаргаснаар зээлдэгчид зээлийн хугацааг уртасгах, зээлийн хүүг бууруулах (одоогийн сарын 2,5%-4,5%-тай хүүгээс) зэрэг зээлийн ашигтай нөхцлүүдийг ярьж хэлэлцэх таатай орчин бүрдэнэ. **Зээлийн баталгаа хөтөлбөр нь 2004 оноос хойш ч хөтөлбөрийн холбогдох туслах зардлууд (ажилчдын цалин, үйл ажиллагааны зардал г.м.)-ыг санхүүжүүлэх санхүүжилтийг үргэлжлүүлэн авах аймгуудад үргэлжлэн хэрэгжинэ. Энэ нь Мерси Корын баталгаатай санхүүжилт авсан дор хаяхад говийн 6 аймагт 2008 оныг дуустал хэрэгжих болно.**

Аудитын тайланд урьд тэмдэглэснээр АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн 2000 оны хөтөлбөрийн "Цагаан Хувьсгал" сүүн бүтээгдэхүүний төсөл одоо ч гэсэн хэрэгжиж байна.

10) АНУ-ын Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, технологийг сурталчлах төслийн мөнгөний зарцуулалтад хяналт тавиагүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 1.35-т: "Мерси Кор 2003 оны хэлэлцээрийн АНУ-ын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, технологийг Монголд сурталчлах зорилгыг хэрэгжүүлэхээр Газар Тариалан Хөгжүүлэх Сан төрийн бус байгууллагатай гэрээ хийж, төслийн менежерээр АНУ-ын иргэн Жим Двайрыг ажиллуулжээ. Үүний дагуу Газар Тариалан Хөгжүүлэх Санд 45 сая төгрөг шилжүүлсэн боловч зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд нь хяналт тавиагүй байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 23-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Энэ бол Газар Тариалан Хөгжүүлэх Санд олгосон тэтгэлэг байсан, гэрээ байгуулаагүй. Жим Двайрыг Мерси Кор бус Газар Тариалан Хөгжүүлэх Сан хөлсөлж ажиллуулсан. Мерси Кор буцалтгүй тусламжийн хэлэлцээр ёсоор ажлын сарын тайлангуудыг хүлээн авч байсан.

Аудитын тайлангийн Бүлэг 1.36-т: "Аудитаар Жим Двайрын цалинд сар бүр 2.4 сая төгрөг олгож, төслийн мөнгөний 44 хувь буюу 19,8 сая төгрөг зарцуулсан, бусад зардлын ихэнх нь баримтгүй байв. АНУ-ын хөдөө аж ахуй, хүнсний салбарын 100 гаруй томоохон аж ахуй нэгжийн үйлдвэрлэдэг техник, технологи, бүтээгдэхүүнийг судалсан мэдээллийн сан бүрдүүлсэн эсэхийг үзэх гэхэд компьютер эвдэрсэн гээд үзүүлээгүй болно" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 24-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Аудитын үеэр компьютер эвдэрсний улмаас мэдээллийн санг үзэх боломжгүй болсон боловч мэдээллийн сангийн хуулбарыг өнгөрсөн оны сүүлээр АНУ-ын худалдааны ажилтан ноён Майкл Ричмонд-д өгсөн. Мерси Кор "Агрпромо"-гоос байгаа бүх санхүүгийн баримт бичиг ба банкны шилжүүлгийг хүлээж авсан. Энэ нь "Агрпромо"-ийн хувьд АНУ-ын Засгийн газраас тэтгэлэг авч АНУ-ын

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

Засгийн газрын журамд нийцүүлж санхүүгийн бүртгэл тайлан хийж суралцах анхны туршлага байсан боловч зарлагыг шаардлагын хэмжээнд баримтжуулж чаджээ.

11) Мерси Кор 2005 оноос дотоод хяналттай болсон ч хөгжлийн төслүүд хөндлөнгийн хяналтгүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 1.37-т: "2005 оноос өмнө Мерси Кор дотоод хяналтын зохих системгүй байсныг аудитаар илрүүлсэн. 2005 оноос Мерси Кор дотоод аудитортой болсон нь үр нөлөөтэй дотоод хяналтыг бүрдүүлж өгчээ. Гэхдээ хөгжлийн төслүүд хөндлөнгийн хяналтгүй буй нь хяналтын нийт системийн үр нөлөөг бууруулж байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 25-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн төслүүд нь Мерси Кор-ын дэлхийн даяар хэрэгжүүлдэг АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй бүх төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтыг шалгадаг аудитын тогтолцоонд хамрагдаж, Прайс Уотерхаус Күперс хэмээх хөндлөнгийн аудитын фирмээр аудитээ гүйцэтгүүлдэг. Мерси Кор байгууллага 2001 оноос хойш дотоодын хяналтыг нэвтрүүлсэн бөгөөд дотоод аудитор нь 2002 оны 11-р сард Монголын төсөл хөтөлбөрүүдэд аудит хийсэн.

12) Мерси Корын өгсөн мэдээлэл гүйцэтгэлийг үнэлэхэд хангалтгүй байсан

Аудитын тайлангийн Бүлэг 1.38-т: "Мерси Корын 2002, 2003 оны тайланд тусгагдсан мэдээлэл нь борлуулалтын орлогыг ашиглах чиглэлийг мөрдсөн эсэх, төслийн шалгуурууд бүрэн хангагдсан эсэхийг гол сонирхогч талууд болох Гадаад Харилцааны Яам, АНУ-ын ЭСЯ, АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент тодорхойлоход хангалтгүй байжээ. Энэ нь дэд төслүүдэд зарцуулсан мөнгө болон хамрагдагсдын тоог тэр бүр бүртгэдэггүй байсантай холбоотой" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 26-г үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Буцалтгүй тусламжийн холбогдох хэлэлцээрүүдийн нөхцөл заалтуудын дагуу АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментэд өгсөн бүх тайлангууд хэлэлцээрийн тайлагнах шаардлагуудад нийцэж буй. АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент ч тэр, АНУ-ын ЭСЯ ч тэр энэ талаар ямар нэгэн гомдол дургүйцэл илэрхийлж байгаагүй. Түүнчлэн, Мерси Кор жилийнхээ дэлгэрэнгүй тайлангуудыг Монголын холбогдох яамд газруудад өгч байсан хэдий ч аль нь ч асууж тодруулах юмуу тайланг хүлээж авсан тухайгаа эргэж мэдэгдэж байгаагүй. Вашингтон хот дахь Монгол улсын ЭСЯ л тайлангуудыг хүлээж авсныг албан ёсоор мэдэгдэж Монголын ард түмэнд дэмжлэг тусалцаа үзүүлж буй явдалд талархал илэрхийлсэн.

Аудитын тайлангийн Бүлэг 1.39-т: "АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментэд өгсөн 2000 оны тайланд амьжиргааг дэмжих төслийн мөнгийг ашгийн төлөө ажилладаг хувийн Хас банкинд оруулж, үүний дагуу Мерси Кор гол хувьцаа эзэмшигчдийн нэг болж, Төлөөлөн Удирдах Зөвлөлд төлөөллөө оруулж, цалин, ноогдол ашиг авах эрхтэй болсон, зээл олгох үйлчилгээ нь Хас банкны үйлчилгээтэй ямар холбоотойг бичээгүй. Мөн 2002 оны тайланд улаан буудайн борлуулалтын орлогын 90 гаруй хувийг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын Говийн Санаачлага хөтөлбөрийн тав дахь жилийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашигласнаа бичээгүй" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 27-г үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Хэлэлцээрээр баталсан "..... төрөлжүүлсэн сургалт ба зээл олголтыг" дэмжих стратеги (тусламжийн хэлэлцээрийн Бүлэг E2)-ийн дагуу хөрөнгийг Мерси Кор-ын санаачилсан "Говийн Эхлэл" жижиг зээлийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагаанд зориулж олгосон. Урьд дурдсанчлан, Говийн Эхлэл нь цаашдаа Нэгдсэн Үндсэн Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн "Микростарт" төсөлтэй нэгдсэнээр Хас банкыг үүсгэн байгуулсан бөгөөд ийнхүү нэгдэж Хас банкыг үүсгэн байгуулсан явдлыг Монголын Засгийн газрын байгууллагууд зөвшөөрсөн. Хас банк дахь Мерси Кор-ын хөрөнгө оруулалт болох хувьцааг худалдаж хөрөнгийг нь хэрхэн

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

хуваарилж зарцуулах төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй дурдсан албан захидлын хуулбарыг АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент мөн хүлээж авсан.

Урьд өмнө дурдсанчлан (аудитын тайлангийн Бүлэг 1.30-д өгсөн Мерси Кор-ын тайлбар), АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн 2002 оны санхүүжилт нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын санхүүжилтийг ОРЛОХ бус харин шаардлагатай хэмжээнд нь ХҮРГЭЖ, НЭМЭГДҮҮЛЭХ зориулалттайгаар ашиглагдсан. Түүнчлэн, "хэдий санхүүжилт удсаны улмаас хөтөлбөрийн үйл ажиллагааг шинэ аймгуудад өргөжүүлэх ажил саатсан ч 2003 оны 9-р сард Мерси Кор Ховд, Завхан, Архангай, Сүхбаатар болон Дорноговь зэрэг зэргэлдээ 5 аймагт эрэлт хэрэгцээний нарийвчилсан үнэлгээ хийж АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн 2003 оны хөтөлбөрийн хүрээнд дээрх аймгуудад үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Бизнес сургалтын эхний үйл ажиллагаа 2003 оны 10-р сард Дорноговь аймагт явагдсан".

13) Монгол улсын Засгийн газрын байгууллагууд улаан буудайн төслийг хянаж шинжлэх үүргээ биелүүлээгүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 2.7-т: "2000, 2002, 2003 оны хэлэлцээрийн дагуу аймаг, орон нутгийн удирдлага Мерси Кор болон сайн дурын бусад байгууллагаас орон нутагт хэрэгжүүлж буй хөгжлийн төслүүдийн явц, үр дүнг хянах үүрэгтэйг Гадаад Харилцааны Яамнаас мэдэгдээгүй байна. Тиймээс аймаг орон нутгийн удирдлага хөгжлийн төслүүдийг огт хянаагүй байна" гэжээ.

**ҮАГ-ын тайлбар
28-ыг үзнэ үү.**

Мерси Кор-ын тайлбар: Мерси Кор өөрийн бүх төсөл хөтөлбөрүүдээ холбогдох аймаг орон нутгийн удирдлагатай нягт хамтран ажиллаж хэрэгжүүлсэн. Эдгээр орон нутгийн удирдлага хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож бүхий л дэмжлэг туслалцаа үзүүлж байсан.

14) 2003 оноос хойш төсөл хэрэгжүүлэхэд Монгол улсын Засгийн газар оролцоогүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 2.8-т: "2003 оноос хойш Гадаад Харилцааны Яам улаан буудайн төсөлд оролцоогүй бөгөөд Удирдах Зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаагүй байна. Уг үүрэг хариуцлага Сангийн Яаманд шилжсэн ба Мерси Корын тайлангийн хувийг Сангийн Яам хүлээн авч байв. Хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өдөр тутмын яриа хэлцэлд Монгол улсын Засгийн газар оролцохоо больсон ч 2000, 2002, 2003 оны улаан буудайн борлуулалтын орлогоор санхүүжсэн төслүүдийн зарим нь үргэлжлэн хэрэгжиж, зарим нь дөнгөж эхэлж байв. Энэ нь ихэнх төслийг хэрэгжүүлэхээр Монгол улсын Засгийн газраас томилсон төлөөний агент болох Мерси Кор Монгол улсын Засгийн газрын хяналт удирдлагагүйгээр шийдвэр гаргаж, төслүүдийг хэрэгжүүлж байсан гэсэн үг юм. Энэ нь дотоод хяналт, хариуцлагыг сулруулан, зүй бус үйл ажиллагаа хийгдэх, илрэхгүй байх эрсдэлийг ихэсгэжээ" гэжээ.

**ҮАГ-ын тайлбар
29-ийг үзнэ үү.**

Мерси Кор-ын тайлбар: Мерси Кор төслүүдээ тусламжийн хэлэлцээрийн дагуу бүрэн хэрэгжүүлсэн. Үүргийнхээ дагуу донор болох АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департамент болон АНУ-ын ЭСЯ-нд тухай бүрт тайлагнаж байсан. Түүнчлэн, шаардсаны дагуу тайлангуудыг Монгол улсын Засгийн газарт өгч байсан.

15) Улаан буудайн борлуулалтын орлогоос Хас банкинд оруулсан хөрөнгийг хэлэлцээр дуусахад татаж аваагүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 2.9-т: "АНУ, Монгол улсын Засгийн газар хоорондын жил тутмын хэлэлцээрийг 2003 оны эцсээс дахин байгуулаагүй ажээ. Тэр үед АНУ-аас Монгол улсын Засгийн газарт хандивласан улаан буудайн борлуулалтын орлогоос

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

774,0 сая төгрөгийг Мерси Кор Хас банкинд хөрөнгө оруулалт болгоод хийчихсэн байсан. Энэ мөнгө бол Монгол улсын Засгийн газрын хөрөнгө болохоос Мерси Корын хөрөнгө биш юм. Тиймээс АНУ, Монгол улсын Засгийн газар хоорондын жил тутмын сүүлийн хэлэлцээр дуусах үед Монгол улсын Засгийн газар уг мөнгийг "Хүнс - хөгжил дэвшлийн төлөө" хэмээх 1985 оны хуулийн дагуу Монголд ашиглахаар эргүүлж өгөхийг шаардах эрхтэй байсан. Гэтэл Гадаад Харилцааны Яам мөнгийг буцааж авах талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 30-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Урьд өмнө дурдсанчлан, эдгээр хөрөнгийг АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн 2000 оны хэлэлцээр дэх "хөрөнгийн ашиглалт" тодотголуудаар хүлээн зөвшөөрсний дагуу Мерси Кор-ын байгуулсан жижиг зээлийн үйлчилгээг дэмжих үйл ажиллагаа явуулах "Говийн Эхлэл" төсөл зарцуулсан. Хөрөнгийг хөдөө орон нутгийн иргэдэд зээл олгох эрхэм зорилготой арилжааны банк болох Хас банкны дүрмийн санд арвижуулахад туслах зорилгоор ашигласан. Мерси Кор энэ тухай АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн төлөөлөх АНУ-ын ЭСЯ-нд тодорхой мэдэгдэж орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх ижил хөтөлбөрүүдэд ашиглах хөрөнгийн хуваарилалтын төлөвлөгөөгөө танилцуулсан. АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн 2000 оны төсөл одоогоор дуусаагүй, хаагдаагүй байгаа.

Аудитын тайлангийн Бүлэг 2.10-т: "2000, 2002, 2003 оны хэлэлцээрийн дагуу улаан буудайн орлогын 591.2 сая төгрөг зээлийн барьцаанд ашиглагдаж байгаа бөгөөд энэхүү мөнгийг зээл нь эргэн төлөгдөхөд мөн эргүүлж татах ёстой" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 31-ийг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Урьд өмнө дурдсанчлан, Монгол улсын Засгийн газарт буцааж өгөх тухай заалт байхгүй. 2003 оны хөтөлбөрийн хөрөнгийн ашиглалтын тухай тус хөтөлбөрийг хамардаг тусламжийн хэлэлцээрт дурдсан байгаа (аудитын тайлангийн Бүлэг 1.34-т Мерси Кор-ын өгсөн тайлбар).

16) АНУ-ын улаан буудайн төсөлтэй холбоотой залилангийн эрсдэлүүдийг үр нөлөөтэй үнэлж, удирдаагүй байна

Аудитын тайлангийн Бүлэг 2.11-т: "1990-ээд оны сүүлчээр Монгол улсын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам улаан буудайн төслийн хэрэгжүүлэгч байхад АНУ-ын улаан буудайг худалдан авагчид залилан, зүй бус үйлдэл хийсэн талаар мэдээлэл гарч байсан. АНУ-ын Элчин сайдын хүсэлтээр Монгол улсын Төрийн Хянан Шалгах Хороо (хуучин нэрээр) 1997 оны тусламжийн улаан буудайг хүлээн авч, орлого бүрдүүлсэн байдалд шалгалт хийж, шалгалтын дүнгээр Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамны Төрийн нарийн бичгийн дарга ажлаасаа халагдсан. АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментад өгсөн Мерси Корын 2002 оны тайланд өмнөх онд нь улаан буудайн борлуулалтын хөтөлбөрийн менежертэй холбоотой авилгалын хэрэг гарсныг дурдсан нь зүй бус үйлдлийн өөр нэг жишээ юм" гэжээ.

ҮАГ-ын тайлбар 32-ыг үзнэ үү.

Мерси Кор-ын тайлбар: Мерси Кор-ын удирдсан 2000, 2002 ба 2003 оны улаан буудайг борлуулах үйл явц болон борлуулалтын орлогоор нь Мерси Кор-ын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой ямар ч залилангийн хэрэг гарч байгаагүй. Аудитын тайланд тэмдэглэснээр 1998 оны улаан буудайг борлуулах хөтөлбөрийг Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам хариуцаж байх үед залилангийн ноцтой хэрэг гарч байсан.

17) Зөвлөмж

ҮАГ-ын тайлбар 33-ыг үзнэ үү.

Нэг: "Хас банкинд хөрөнгө оруулалт хийсэн 774,0 сая төгрөгийг Мерси Короос хүүгийн хамт авч 2000 оны хэлэлцээрт заасан төслүүдэд зарцуулах".

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

Мерси Кор-ын тайлбар: Энэ бол үндэслэлгүй зөвлөмж гэж үзэж байна - **Бүлэг 1.29-д** өгсөн тайлбарыг хар.

Хоёр: "Зээлийн баталгааны хөтөлбөрт зориулан банкуудад байршуулсан 591.2 сая төгрөгийг зээл эргэн төлөгдөх үед эргүүлж авах".

Мерси Кор-ын тайлбар: Энэ бол үндэслэлгүй зөвлөмж гэж үзэж байна - **Бүлэг 1.34-д** өгсөн тайлбарыг хар.

Гурав: "Улаан буудайн тусламж хэлэлцээрийн дагуу хэрэгжиж буй эсэхийг нягтлахыг тулд 2000, 2002, 2003 оны хэлэлцээрээр санхүүжигдсэн бөгөөд одоо үргэлжлэн хэрэгжиж буй төслүүдийн үйл явц, үр дүнг хянах тогтолцоо, горим бүрдүүлэх".

Мерси Кор-ын тайлбар: **Бүлэг 1.5-д** өгсөн тайлбарыг хар - АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Департаментийн 2000 оны хөтөлбөрийн зөвхөн жижиг бүрэлдэхүүн хэсэг нь одоогоор хэрэгжиж буй.

Дөрөв: "2002 улаан буудайн борлуулалтын орлогоос Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачлага хөтөлбөрийн тав дахь жилийн үйл ажиллагаанд зарцуулсан 3,157,026,202 төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилтийг хөгжлийн төслүүдэд нөхөн олгохыг АНУ-ын Засгийн газраас хүсэх".

Мерси Кор-ын тайлбар: Энэ бол үндэслэлгүй зөвлөмж гэж үзэж байна - **Бүлэг 1.30-д** өгсөн тайлбарыг хар.

Мерси Кор-оос хийх залруулга, өгөх тайлбар үүгээр дуусав.

Аудитын тайлан болон тус захидлын агуулгын талаар уулзаж ярилцах боломж олгохыг Мерси Кор танаас хичээнгүйлэн хүсч байна.

Гүнээ хүндэтгэсэн

Шон Гранвилл-Росс
Суурин төлөөлөгч



Хуулбарыг: Л. Эрдэнэчулуун - Монголын Үндэсний Аудитын Газрын шинжээч
С. Жонстон - АНУ-ын ЭСЯ, Улаанбаатар хот, Монгол улс
Н. Саклех - АНУ-ын ХААД, Вашингтон хот, АНУ
С. Зиммерман - Хөтөлбөрүүдийн дэд ерөнхийлөгч, Мерси Кор, АНУ

Мерси Кор-оос ирүүлсэн санал:



www.mercycorps.org.mn

Огноо: 2006 оны 10-р сарын 27

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр

Монгол улсын Ерөнхий аудитор
ноён Л. Жавзмаа танаа

Монголын Үндэсний Аудитын Газрын шинжээч Л. Эрдэнэчулууны Мерси Кор ТББ-ын удирдлагад ирүүлсэн албан захидалд өгөх хариу

Эрхэм хүндэт ноёнтон,

Мерси Кор байгууллага танайхаас ирүүлсэн аудитын мөрөөр ажил зохиох тухай албан тоотыг 2006 оны 10-р сарын 16-нд хүлээн авч улмаар танилцсан бөгөөд тус албан захидалд өгөх хариугаа үүгээр хүргүүлж байна.

Нэг: "Цагаан хувьсгал" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацааны эхний жилийн төсөв буюу 2005 оны фермийн удирдлагын зардалд 7,500 ам. доллар, сургалтын менежерт 62,500 ам. долларыг "Мерси Кор" төрийн бус байгууллага санхүүжүүлэхдээ "Алпайн" ХХК-ийн нэхэмжлэлд дурьдсан удирдлагын зардал гэсэн ангилалаар нэг сард 4,166.66 ам. доллар, бүгд 74,380.48 ам. долларыг шилжүүлсэн байна. Сургалтын менежер ажиллуулсан зардал гэж тайлбарлаж байгаа ч төвлөрсөн сургалт явуулаагүй нь нотлогдсон ба санхүүжүүлэх үндэслэл байхгүй тул уг зардлаар гаргасан санхүүжилтийг цаашид сургалт явуулсан үед нөхөн тооцох.

**ҮАГ-ын тайлбар
34-ийг үзнэ үү.**

Мерси Кор-ын тайлбар: Төслийн эхний жилд сүүний ферм байгуулахтай холбоотой үйл ажиллагаа явуулсан. Тухайлбал, Баянчандмань сумын засаг захиргааны байгууллагатай газрын түрээсийн асуудлыг ярилцах, Монгол орны хойд хэсгээр аялж сүүний чиглэлийн үхрийг олж, худалдаж авах, шинэ ферм рүү түүнийгээ зөөж тээвэрлэх болон фермийн байшин барилга, худаг ба хашаа барих зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн. Фермийг барьж байгуулаагүй ба ашиглалтад оруулаагүй нөхцөлд сургалт явуулах боломжгүй. Сүүний фермийг барьж байгуулах зорилго нь Монголын фермерүүдийг Монголд бэлэн буй барилгын материал ба малын тэжээл ашиглан зүй зохистой зохион байгуулж удирдан ажиллуулж буй сүүний фермийн амьд загвартай танилцуулахад оршино. Фермийг барьж байгуулах ажлын эхний үе дуусч сүүний чиглэлийн үнээтэй болсон бөгөөд төсөл хэрэгжих эхний жилд 16 малчин өрхийг фермд ажилтай болгож тэдэнд сүүний фермийг үүсгэн байгуулах, фермийн менежментийн талын практик сургалт явуулсан. Мөн фермийн ойролцоо оршин суудаг 21 малчин өрх байдаг бөгөөд тэд фермийн менежерээс сургалт авч "Алпайн" загвар фермээс их зүйл сурч авсан. Ферм одоогоор нэгэнт байгуулагдаж бүрэн хэмжээгээрээ ажиллаж буй тул сургалтыг цаашид тогтмол явуулж сонирхож буй Монголын мал үйлдвэрлэгчдийг 7 хоногийн сургалтанд оролцуулахаар урих болно. Эхний сургалтыг 2006 оны 9-р сарын хоёр дахь 7 хоногт амжилттай явуулж 5 хоног үргэлжилсэн уг сургалтанд 6 мал үйлдвэрлэгчдийг хамруулсан (Ховдоос дөрөв, Өвөрхангайгаас хоёр малчин).

Хоёр: Гэрээний 3.В-д "Алпайн" ХХК-д арилжааны зээл авахад туслах зорилгоор 170.000 ам. доллартай тэнцэх барьцааны хөрөнгийг "Мерси Кор" ТББ гаргахаар 2004 оны 5 дугаар сард "Хас" банкинд тусгай данс нээж /198,220,000.00 төгрөг/

24 Peace Ave., Bayanzurkh District
Ulaanbaatar, Mongolia
(+976.11) 46.11.45 tel
(+976.11) 46.10.48 fax
postmaster@mercyorg.mn

3015 SW First Avenue17
Portland, OR 97201
503.796.6800 tel
503.796.6844 fax

Claremont Crescent
Edinburgh
Scotland, UK EH7 4HX
+44.131.558.8244 tel
+44.131.558.8288 fax

Мерси Кор-оос ирүүлсэн санал:

байршуулжээ. Зээлийн зарцуулалт, ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж төслийн эдийн засгийн үр өгөөжийг тооцох.

Мерси Кор-ын тайлбар: "Алпайн" ХХК нь банкнаас 198,220,000 төгрөгийн арилжааны зээл авч 217 үхэр, үхэр хариулах 26 морь, шинэ Пажеро жип, өвөл малдаа өгөх өвс хадлан, малын тэжээл, фермийн өдөр тутмын ажиллагааны түлшний зардал, өвс тэжээл болон худалдаж авсан үхрүүдээ Монголын хойд хэсгээс фермд авчирах тээврийн зардал, фермийн ажилчдын цалин зэрэг зүйлд зарцуулсан болно.

Монгол улсын хөдөөгийн суманд сүүний ферм үүсгэн байгуулах, удирдан ажиллуулах эдийн засгийн үр ашгийг тодорхойлох зорилгоор Мерси Кор одоогоор фермийн судалгаа явуулж байна.

Мерси Кор-оос хийх залруулга, өгөх тайлбар үүгээр дуусав.

Аудитын тайлан болон тус захидлын агуулгын талаар уулзаж ярилцах боломж олгохыг Мерси Кор танаас хичээнгүйлэн хүсч байна.

Гүнээ хийдэгтэсэн

Шон Грэвилл-Росс
Суурин төлөөлөгч



Хуулбарыг: Л. Эрдэнэчулуун - Монголын Үндэсний Аудитын Газрын шинжээч
С. Жонстон - АНУ-ын ЭСЯ, Улаанбаатар хот, Монгол улс
Н. Саклех - АНУ-ын ХААД, Вашингтон хот, АНУ
С. Зиммерман - Хөтөлбөрүүдийн дэд ерөнхийлөгч, Мерси Кор, АНУ

Мерси Кор-оос ирүүлсэн саналд өгөх тайлбар

ҮАГ-ын тайлбар 1

Аудит хийх үед 2003 оны борлуулалтын орлогоор санхүүжсэн зээлийн баталгааны хөтөлбөр үргэлжилж, зээлийн баталгааны мөнгө банкууд дээр байршиж байсан. Түүнчлэн аймгуудад шилжүүлээд байгаа 226.3 сая төгрөг 2003 оны улаан буудайн орлого бөгөөд хамгийн сүүлчийнх нь 2006 оны 4 дүгээр сарын 30-нд шилжсэн. Иймд 2002 оныг хасч, “2000, 2003 оны борлуулалтын орлогоор санхүүжсэн зарим төсөл” гэж засвар хийлээ.

ҮАГ-ын тайлбар 2

Аудит 2000, 2002, 2003 оны хэлэлцээрийг хамарсан. Мерси Кор ГХЯ-ны хооронд байгуулсан 2000 оны гэрээнд “Хэрэглэгчдэд хандивын эх үүсвэрийн талаар ойлголт өгөх зорилгоор төслийг сонин хэвлэл, телевиз болон радиогоор сурталчлахад нь МУЗГ-т туслалцаа үзүүлнэ” гэж Мерси Корын үүргийг заасан байна. Сурталчилгаа сайн хийсэн гэж санал тайлбарт дурдсан ХАБДХ нь зөвхөн 2003 оны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн учир аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ҮАГ-ын тайлбар 3

“2000 оны борлуулах үнийг хэрхэн тооцоолсныг хэлэхээс Мерси Кор татгалзсан” гэснийг “2000 оны борлуулах үнийг хэрхэн тооцоолсныг Мерси Кор тайлбарлаагүй” гэж найрууллаа.

ҮАГ-ын тайлбар 4

Тайланд “Хэлэлцээрээр улаан буудай, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дахин борлуулах буюу экспортлох, аль эсвэл дотоодынхоос өөр зориулалтаар ашиглахыг хориглосон. Гэтэл Мерси Кор ч, Монгол Улсын Засгийн газар ч тусламжийн улаан буудай, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортлохоос сэргийлэх шалгалт хийсэн гэх нотлох зүйл бидэнд олдоогүй бөгөөд улаан буудай, түүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортолсон байж болох эрсдэл бий” гэж өөрчлөв.

ҮАГ-ын тайлбар 5

“Бусад хөрөнгө” гэснийг “бусад хөдлөх хөрөнгө” гэж өөрчлөв.

ҮАГ-ын тайлбар 6

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийн дагуу Гадаадын хөрөнгө оруулалттай компани нь Монгол Улсын хуулийн этгээд байдаг бөгөөд энэ талаар дэлгэрэнгүй зүйлийг аудитын тайланд оруулах шаардлагагүй юм.

ҮАГ-ын тайлбар 7

Аудитын багаас Төв аймгийн Баянчандмань сумын нутагт “Алпайн” ХХК-ийн эрхэлж буй үйл ажиллагаатай танилцахад тус компанийн удирдлагаас сүү үйлдвэрлэж, борлуулалт хийсэн гэдгээ бодит баримтаар баталгаажуулж чадаагүй билээ. Мөн хөтөлбөрийн талаар орон нутгийн иргэд сэтгэл дундуур байгаагаа хэлж байсныг дурдах нь зүйтэй юм. Тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.

Мерси Кор-оос ирүүлсэн саналд өгөх тайлбар

ҮАГ-ын тайлбар 8

Хөтөлбөрийг хэрэгжүүлж “Алпайн” компанийн хэрэгжүүлж буй төслийн явц хангалтгүй бөгөөд төслийн хүлээгдэж буй үр дүн тодорхойгүй байна. Төсөлд зориулсан 625.8 сая төгрөгийн зарим хэсэг “Алпайн” компанийн бизнесийн эргэлтэд орсон ба үлдэх хэсэг нь ирээдүйд орох учир тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй юм.

ҮАГ-ын тайлбар 9

2002 оны санхүүжилтээр Мерси Корын хэрэгжүүлж буй хөтөлбөрийг 18 аймаг болгон өргөжүүлэх ёстой. Гэвч энэ мөнгөөр Говийн санаачлага хөтөлбөрийн өмнө нь хэрэгжүүлж байсан 6 аймагтаа л хэрэгжүүлсэн. Аудитад хоёр орны Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үзүүлэлтийг шалгуур болгосон тул тайланд өөрчлөлт оруулах боломжгүй юм.

ҮАГ-ын тайлбар 10

2003 оны хэлэлцээрт ХАА-н сэдэвт радио нэвтрүүлгийн үр өгөөжийг хүртэгсдийн тоог 350000-д хүргэх зорилт дэвшүүлсэн атал танайхаас ирүүлсэн саналд 100000 хүн үр өгөөжийг хүртэх ёстой гэж ташаарсан байна. Мөн ХААД-д өгсөн тайланд 187500 хүн ойролцоогоор радио нэвтрүүлгийн үр өгөөжийг хүртсэн, манайд өгсөн саналд 103105 хүн үр өгөөжийг хүртсэн гэжээ. Эндээс үзэхэд Мерси Корын гаргасан тоон үзүүлэлтүүд зөрүүтэй байна. Аудитын тайланд өөрчлөлт хийх боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 11

“Си-Эйч-Эф-ийн төслийн талаар тайлагнах үүргийг Мерси Кор хүлээгээгүйгээс” гэсэн тодотгол хийлээ.

ҮАГ-ын тайлбар 12

Энэ заалт Мерси Кор-д хамаагүй учир тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 13

АНУ-ын ОУХА-ын санхүүжилтийг 2000 оны хэлэлцээрт заасан зорилтыг хэрэгжүүлэхэд зарцуулсан гэсэн нотлох зүйл байхгүй учир тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй болно.

ҮАГ-ын тайлбар 14

АНУ-ын ОУХА-ын Говийн санаачлага хөтөлбөр бол АНУ-ын ХААД-ын улаан буудайн төслөөс өөр төсөл учир тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй юм.

ҮАГ-ын тайлбар 15

Энэ талаар Хас банкнаас ҮАГ-т ирүүлсэн тайлбарт тодорхой дурдсан. Мерси Корын ХЗДХЯ-наас авсан Монгол Улсад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлд “ашиг үл горилох” гэж заасан байгаа. Гэтэл банк бол ашгийн төлөө байгууллага юм. Иймд тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй болно.

ҮАГ-ын тайлбар 16

Хас банкинд оруулсан хөрөнгө оруулалтыг НББОУС-ын дагуу “Урт хугацаат хөрөнгө оруулалт” хэлбэрээр тайлагнах ёстой атал зардалд тусгасан. Тайланд буцааж авах

Мерси Короос ирүүлсэн саналд өгөх тайлбар

ёстой мөнгө гэдгийг илэрхийлж чадахгүй байна гэсэн нь ХААД-д буцаах тухай биш, Мерси Кор авч өөр төсөлд зарцуулах буюу Монгол Улсын Засгийн газарт өгөх мөнгө гэдгийг илэрхийлж чадахгүй байгааг дурдсан юм.

Мерси Кор нь Хас банкны хувьцаа эзэмших санаатай буйгаа АНУ-ын ХААД-д мэдэгдсэн” гэж манай тайлангийн төсөлд ирүүлсэн санал тайлбарт дурдсан. Гэвч Хас банкийг 2001 оны 12 сард байгуулсан. Бидэнд үзүүлсэн дээрх захидлуудыг банк байгуулснаас 2.5 жилийн дараа буюу 2004 оны 6 сард АНУ-ын ЭСЯ болон Мерси Корын АНУ дахь төвд хүргүүлсэн гэх боловч зохих хариу байхгүй, хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл эхэлж Хас банкинд мөнгөө оруулчихаад 2 жил 5 сарын дараа зөвшөөрөл хүсч захидал явуулсан харагдаж байна.

ҮАГ-ын тайлбар 17

Энэ хэсэгт бид 2000 оны улаан буудайн орлогын зарцуулалтын талаар бичсэн тул 2003 оны улаан буудайн борлуулалтын орлогоор хэрэгжүүлэх зээлийн баталгааны хөтөлбөрийг ХААД баталгаажуулах нь хамаагүй юм. Иймд тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй болно.

ҮАГ-ын тайлбар 18

ГБЭЗХС хөтөлбөрийн 5 дахь жилийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашигласан нь нэгэнт тогтоогдсон. Санхүүжилтэд нэмэлт болгосон ба санхүүжилтийг орлосон гэдгийн хооронд зарчмын ялгаа байхгүй. Хэлэлцээр ёсоор хөтөлбөрийн 6 аймгийг 18 болгон өргөтгөх ёстой байсан. Аудитын тайлангийн төсөлд Мерси Короос ирүүлсэн саналыг хэлэлцсэн 2006 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн уулзалтаар дээрх ГБЭЗХС хөтөлбөрт зарцуулах тухай шийдвэрийг бидэнд ирүүлэхээр тохиролцсон ч ГБЭЗХС хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээг жил бүрээр харуулсан баримт л ирүүлжээ. Иймд тайланд өөрчлөлт хийх боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 19

2002 оны хэлэлцээр ёсоор Мерси Кор-ын хэрэгжүүлж буй Хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрийг өргөтгөж, 6 аймгийг 18 хүртэл нэмэгдүүлэх, өргөтгөхдөө нийт санхүүжилтийг мал аж ахуйн менежмент, бэлчээрийн нөөцийн менежмент, усны нөөцийн менежмент, хувийн хэвшлийн менежмент гэсэн дөрвөн хэсэгт тус бүр 25 хувиар зарцуулахаар тусгажээ. 4 хэсэг тус бүр 25 хувь гэдэг нь 4 тэнцүү гэсэнтэй утга ижил юм. Гэтэл гүйцэтгэлээр санхүүжилтийн 85 хувийг үйл ажиллагааны зардалд, үлдэх 15 хувийг хөтөлбөрийн зардалд зарцуулсан, үйл ажиллагааны зардал бол удирдлагын зардал юм. Иймд тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй болно.

ҮАГ-ын тайлбар 20

2002 оны хэлэлцээрт ажилгүйдлийн даатгалын сан байгуулахад хөрөнгө зарцуулах заалт байхгүй. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1 “Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно” гэж заасан ба ажилгүйдлийн даатгалын сан байгуулна гэж заагаагүй. Иймд тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй юм.

ҮАГ-ын тайлбар 21

Банкуудтай байгуулсан гэрээнд зээлийн хүүг бууруулах талаар заалт байгаагүй, хүү буурсан талаар өөр баримт үзүүлээгүй болно. Мерси Кор болон банкны хооронд

Мерси Короос ирүүлсэн саналд өгөх тайлбар

байгуулсан гэрээнд дээрх нөхцөлийг тусгаснаар хэрэгжих үндэстэй болох юм. Албан бичиг бол зөвхөн Мерси Короос тавьж буй санал учир хэрэгжих баталгаа байхгүй. Иймд тайланд өөрчлөлт хийх боломжгүй.

ҮАГ-ын тайлбар 22

Улаан буудайн борлуулалтын орлого нь АНУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт үзүүлсэн тусламжийн хөрөнгө учраас Монгол Улсын Засгийн газрын өмч юм. Мерси Кор бол гэрээний дагуу зарцуулах үүрэгтэй төлөөний байгууллага. СЭЗЯ-ны Мерси Кортой байгуулсан улаан буудайн борлуулалтын орлогыг зарцуулах гэрээний хүчинтэй хугацаа 2005 оны 10 сарын 31 хүртэл байгаа ба зээлийн баталгаа хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2006 оны 1 дүгээр сар гэж дээрх гэрээнд заасан тул Мерси Кор-ын зарцуулалтын эрх дууссан байна. Иймд тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй болно.

ҮАГ-ын тайлбар 23

Мерси Кор нь Монголын ТББ-д дэмжлэг үзүүлэх тендер зарлаж Газар тариалан хөгжүүлэх сантай гэрээ хийсэн боловч нэрийг нь ашигласан төдий байна. Аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 24

Шаардлагын хэмжээнд баримтжуулсан гэж үзэх боломжгүй. Аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 25

Мерси Кор нь 2005 оноос аудитор гэсэн орон тоо гаргаж нягтлан бодогчоор ажиллаж байсан ажилтныг томилсон. Энэ ажилтан зөвхөн аймгуудад өгсөн санхүүжилтийн зарцуулалтад л хяналт тавьдаг, Улаанбаатар дахь Мерси Кор-ын зарцуулалтад хяналт тавьдаггүй. Мөн хэрэгжүүлсэн төсөл тус бүрээр гүйцэтгэлийг зорилт тус бүртэй харьцуулан үнэлсэн хөндлөнгийн хяналтын байгууллагын дүгнэлт үзүүлээгүй болно. Аудитын тайланд өөрчлөлт оруулах боломжгүй.

ҮАГ-ын тайлбар 26

Мерси Корын АНУ-ын ХААД-д өгсөн тайлан хэлэлцээрийн зорилт тус бүр хэрхэн биелснийг дүгнэхэд хангалтгүй байгааг аудитын тайланд дурдсан бөгөөд энэ талаар харьцуулсан судалгаа хийснийг хавсаргав (Хавсралт 1-ийг үз). Аудитын тайланд өөрчлөлт оруулах боломжгүй гэж үзэв.

ҮАГ-ын тайлбар 27

Аудитын тайланд өөрчлөлт оруулах боломжгүй гэж үзэж байна.

ҮАГ-ын тайлбар 28

Энэ заалт Мерси Кор-д бус Монгол Улсын Засгийн газарт хамаарах бөгөөд орон нутгийн захиргааны байгууллагууд хяналт тавиагүй нь аймгуудад хийсэн аудитын тайланд тусгагдсан. Тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй.

Мерси Короос ирүүлсэн саналд өгөх тайлбар

ҮАГ-ын тайлбар 29

Энэ нь Мерси Кор-д хамааралгүй, Монгол Улсын Засгийн газрын хяналтын тухай асуудал юм. Тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 30

Энэ нь Мерси Кор-д хамааралгүй, Монгол Улсын Гадаад хэргийн яамтай холбоотой заалт тул тайланд өөрчлөлт хийх шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 31

Хэлэлцээрээр улаан буудайг АНУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламж болгон нийлүүлсэн нь Монгол Улсын Засгийн газрын өмч гэдгийг баталж байгаа юм. Тийм учраас борлуулалтын орлогыг Монгол Улсын Засгийн газарт өгөх ёстой. Аудитын тайланд засвар хийх шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 32

Тайлангийн энэ хэсэгт Мерси Кор-ыг хөтөлбөрийн хэрэгжүүлэгч байх үед залилан гарсан гэж дурдаагүй. Сэлэнгэ аймгийн гурил тэжээлийн үйлдвэрт улаан буудай хадгалагдаж байх үед залилан гарч холбогдох албан тушаалтан шүүхийн шийдвэрээр тэнсэн харгалзах ял хүлээсэн тохиолдол ч байжээ. Иймд аудитын тайланд засвар хийх шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 33

Тайланд зарчмын өөрчлөлт ороогүй тул зөвлөмжийн агуулга өөрчлөгдөхгүй болно.

ҮАГ-ын тайлбар 34

Тайлбар 7-г үз.

Тусламжийн гэрээний зорилт, шалгуурыг Мерси Короос АНУ-ын Хөдөө аж ахуйн департаментад өгсөн үр дүнгийн тайлантай харьцуулсан байдал

2000 оны гэрээ, Мерси Корын тайлан.

/Тайлангийн огноо: 2005 оны 10 дугаар сарын 25/

Үйл ажиллагааны зорилтууд:

Монголын Улсын Засгийн газар дараахь зүйлийг үргэлжлүүлэн хийнэ:

- Газар хувьчлал, мал аж ахуй, тариалан эрхлэх үйл ажиллагаа, фермийн үйлчилгээг дэмжинэ;
- Дэд бүтцийн асуудлыг шийдсэнээр малчид, тариаланчид бүтээгдэхүүнээ хот суурин газар арилжих боломжийг нэмэгдүүлэн тэдний амьжиргааг дээшлүүлэхэд туслах;
- 1999-2000 оны өвлийн гамшигт малаа алдсан малчдын амьжиргааг мал олгох, усны менежмент, бэлчээрийн менежмент, сургалтын хөтөлбөр зэргийг ашиглан нөхөн сэргээх.



Борлуулалтын орлогын дүн – 4,687,447,790 төгрөг

2000 оны гэрээнд заасан шаардлага	Мерси Короос АНУ-ын ХААД-д өгсөн тайланд бичигдсэн үр дүн
Нийт орлогын 50 хувийг фермийг зах зээлтэй холбох замын төсөлд зориулах ба санхүүжилтийн 50 хувийг 5 дугаар сард олгож, үлдсэн хэсгийг 45 хоногийн зайтай 15 хувиар олгоно	Үр дүнг тэмдэглээгүй 2,500,176,433 төгрөгийг АНУ-ын Элчин сайдын яаманд шилжүүлсэн нь орлогын 53.3 хувь
<ul style="list-style-type: none"> · Орлогын 20 хувийг амьжиргааг дэмжих төсөлд ашиглана. 2 хувааж олгох ба 50 хувийг 4 дүгээр сард ажил эхлэх үед, 50 хувийг 2001 оны 7 дугаар сард; · Тусламж нь малын менежмент, усны болон худгийн засвар үйлчилгээ, орон нутгийн үйл ажиллагаатай холбоотой хувийн хэвшлийг хөгжүүлэх, түүнд тусгай сургалт явуулах, зээл олгох үйл ажиллагаа орно. 	<p>Мерси Кор тайландаа “худаг нөхөн сэргээх, сургалтын үйл ажиллагааг өөр хөтөлбөрийн дагуу санхүүжүүлсэн” гэж бичсэн</p> <p>Мерси Кор тайландаа “Өмнөх жилд тэмдэглэгдсэн нийт 888.792.260 төгрөгийг “Говийн санаачлага” төслийн үйл ажиллагааг дэмжихэд ашигласан (114,792,260 төгрөг), түүнчлэн “Говийн эхлэл” жижиг зээлийн үйл ажиллагааг “Говийн санаачлага” төслийн хүрээнд хэрэгжүүлж эхэлсэн гэжээ. (774,000,000 төгрөг)”.</p> <p><i>Тэмдэглэл: 888.792,260 төгрөг буюу борлуулалтын орлогын 19 хувь</i></p>
<ul style="list-style-type: none"> · Орлогын 10 хувийг Монгол Улсын Засгийн газрын “Цагаан хувьсгал” төслийг дэмжихэд ашиглана. Хөрөнгийг 2001 оны 3 дугаар сард олгоно. 	<p>“2003 оны 3 сард Мерси Кор 2000 оны борлуулалтын орлогоос нэмэлт 625,785,565 төгрөгийг Монгол Улсын Засгийн газрын “Цагаан хувьсгал” төслийг хөгжүүлэх зорилгоор авсан. Төсөл нь сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сэргээх зорилготой.</p>

	<p>2003 оны 4 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл Мерси Кор нь орон нутгийн сүүн бүтээгдэхүүний компанитай хамтарч Улаанбаатар хотын дэргэд 500 үнээний ферм байгуулах зорилготой төсөл боловсруулсан.</p> <p><i>Тэмдэглэл: Хүлээн авсан гэж бүртгэгдсэн мөнгөн дүн борлуулалтын орлогын 13 хувь. ҮАГ-ын илрүүлснээр хүлээж авсан дүн нь банкинд байршуулсны хүүг оролцуулаад 15 хувь байна. 2000 онтой холбоотой зарцуулсан мөнгөн дүн 287,590,927 төгрөг буюу 6.2 хувь.</i></p>
<ul style="list-style-type: none"> Орлогын 9 хувийг гамшгийн дараах тусламжид ашиглана. Энэ мөнгийг хоёр хувааж олгоно: 50 хувийг 2001 оны 5 дугаар сард, 50 хувийг 2001 оны 9 дүгээр сард олгоно. 	<p>Аррифин компаний вакцины үнийг АНУ-ын Элчин сайдын яамд өгсөн</p> <p>396,000,000 төгрөг буюу 8.4 хувь</p>
<ul style="list-style-type: none"> Орлогын 5 хувийг Мерси Корын үйл ажиллагааны зардалд зарцуулна. Энэ мөнгөний 50 хувийг 2001 оны 3 дугаар сард, үлдсэн 50 хувийг 2001 оны 6 дугаар сард олгоно. 	<p>Улаан буудайн борлуулалтын орлогын 5 хувь буюу 224,680,000 төгрөг</p>
<ul style="list-style-type: none"> Орлогын 2.5 хувийг АНУ болон Монгол Улсад үр өгөөжтэй байх АНУ-ын ХААД-ын ХАА-н шинжлэх ухаан, технологийн төсөлд хэрэглэнэ. Бодит зарцуулалт нь тодорхойлох төслүүдээс хамаарна. 	<p>Үр дүнг тэмдэглээгүй</p>
<ul style="list-style-type: none"> Орлогын 2.5 хувиар Пиис Корпс (Peace Corps) байгууллагын орон нутгийн төслүүдийг дэмжинэ. Санхүүжилтийг хоёр хувааж олгох ба 50 хувийг 2001 оны 4 дүгээр сард, 50 хувийг 2001 оны 9 дүгээр сард; 	<p>Үр дүнг тэмдэглээгүй</p> <p>АНУ-ын Элчин сайдын яаманд өгсөн 112,741,482 төгрөг буюу борлуулалтын орлогын 2.4 хувь.</p>
<ul style="list-style-type: none"> Орлогын 1 хувийг АНУ-ын ХАА-н салбарыг сурталчлах ажилд зарцуулна. Энэ мөнгийг хоёр хувааж олгоно: 50 хувийг 6 дугаар сард, 50 хувийг 2001 оны 9 дүгээр сард; 	<p>Үр дүнг тэмдэглээгүй</p> <p>АНУ-ын Элчин сайдын яаманд ном орчуулах, хэвлэлийн зардал гэж өгсөн 2,700,000 төгрөг буюу 0.06 хувь</p>

Гэрээний хэрэгжилтийн явцыг хэмжих шалгуурыг Мерси Корын үр дүнгийн тайлантай харьцуулсан байдал

Үйл ажиллагааны үр дүнг дараахь шалгуураар хэмжинэ гэж гэрээнд заасан:

Үйл ажиллагаа	Мерси Корын тайланд үр дүнг тэмдэглэсэн байдал
<ul style="list-style-type: none"> Улаан буудайн борлуулалтын орлогын бүрдүүлэлтийн хувь биелсэн байх 	Тэмдэглээгүй

· Төслүүдийн санхүүжилт хуваарийн дагуу бүрэн хийгдсэн байх,	Тэмдэглэгдээгүй. “Цагаан хувьсгал” төслийн санхүүжилт 2 жил хоцорсон
· Мерси Кор төслүүдийн тайланг хугацаанд нь чанартай гаргаж өгөх	Жилд нэг тайлан гаргасан, гэрээний дагуу жилд хоёр удаа гаргах ёстой байсан
· Малчид, газар тариаланчдад зах зээлд холбогдох боломж нэмэгдсэн байх	Тэмдэглээгүй
· Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмж нэмэгдэж, зах зээл сайжирсан байх	<ul style="list-style-type: none"> · 8 малчин өрхөд илүү сайн үүлдрийн үхэр өгсөн · Өвөлжөөг барьж, мал хорогдоогүй · Хөршүүддээ үлгэр жишээ ферм болсон · Нийт 7200 литр сүү боловсруулсан
· АНУ-ын ХААД-ын судалгааны төслийн мөнгийг хугацаанд нь гаргаж өгөх	Тэмдэглээгүй

2002 оны гэрээ. Мерси Корын тайлан. /Тайлангийн огноо: 2004 оны 10 дугаар сарын 1/

Үйл ажиллагааны зорилт: Сүүлийн 10 жилийн эдийн засаг, нийгмийн чиг хандлагыг өөрчлөхийн тулд Монгол Улсын Засгийн газар орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжиж, гамшгийн дараах туслалцааг үзүүлнэ:

- Газар хувьчлал, мал аж ахуй, тариалан эрхлэх үйл ажиллагаа, фермийн үйлчилгээг дэмжинэ;
- Дэд бүтцийн асуудлыг шийдсэнээр малчид, тариаланчид бүтээгдэхүүнээ хот суурин газар арилжих боломжийг нэмэгдүүлэн тэдний амьжиргааг дээшлүүлэхэд туслах;
- Өвлийн гамшигт малаа алдсан малчдын амьжиргааг мал олгох, усны менежмент, бэлчээрийн талбайн менежмент, бизнес хөгжил зэргийг ашиглан нөхөн сэргээх.

Борлуулалтын орлогын дүн – 3,237,336,310 төгрөг

Гэрээний шаардлага	Мерси Корын тайланд үр дүнг тэмдэглэсэн байдал
<ul style="list-style-type: none"> · Борлуулалтын орлогын 92.5 хувийг Мерси Корын хэрэгжүүлж буй эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрийг өргөтгөж 6 аймаг байсныг 18 болгоно. · Хөрөнгийг хөтөлбөрийн дөрвөн холбоотой хэсэгт тэнцүү хуваана. Үүнд малын менежмент (25%), бэлчээрийн нөөцийн менежмент (25%), усны нөөцийн менежмент (25%), хувийн хэвшлийн менежмент (25%). Төслийн хэсэг а, b, c нь ижил түвшний малчин өрхүүдэд хамаарч, хэсэг d-д үр өгөөжийг хүртэх хүмүүсийг тодруулна. 	3,157,026,202 төгрөг борлуулалтын орлогын 97.5 хувь
Борлуулалтын орлогын 2.5 хувийг Мерси Корын үйл ажиллагааг дэмжихэд ашиглана	Улаан буудайн борлуулалтын орлогын 80,933,408 төгрөг буюу 2.5 хувь
Борлуулалтын орлогын 5 хувийг онцгой байдлын үед ашиглахаар нөөцөд байлгана.	АНУ-ын Элчин сайдын яамны онцгой байдлын санд 179,456,689 төгрөг буюу 5.5 хувь

Гэрээний хэрэгжилтийн явцыг хэмжих шалгуурыг Мерси Корын үр дүнгийн тайлантай харьцуулсан байдал

2002 оны үйл ажиллагаа	Мерси Корын тайланд үр дүнг тэмдэглэсэн байдал
<ul style="list-style-type: none"> Онцгой байдлын үед хэрэглэх тусламж: <p>Онцгой байдал бий болсон үед хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр тусламжийн хөтөлбөр, явцыг Монгол Улсын Засгийн газар тодорхойлно</p>	<p>Нийт зарлагыг тэмдэглээгүй</p> <p>МУЗГ-тай энэ талаар харьцаагүй</p>
Хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр:	Зарлагын нарийн мэдээллийг тэмдэглээгүй
<ul style="list-style-type: none"> Мал аж ахуйн менежмент: <p>Төслийн хэрэгжилтийн 12 сарын дараа 6,000 гаруй өрх мал аж ахуйн менежментын шинэ арга зүйд суралцаж, малаа өсгөж, орлогоо нэмэгдүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> 1892 хүнийг оролцуулсан 75 удаагийн малын менежмент, малын үүлдэрийг сайжруулах сургалт явуулсан– [төлөвлөсөн зорилтын 31 хувь] Малчдад дэмжлэг үзүүлж, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлсэн Мал үржүүлэхтэй холбоотой техник туслалцаа үзүүлсэн Ноолуур, малын гаралтай бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг дэмжсэн Орон нутгийн хувийн хэвшлийг дэмжсэн сэтгүүл сард 60,0-70,000 хувь хэвлэгдсэн Малчдын талаархи телевиз, радио нэвтрүүлгийг нэмэгдүүлсэн
<ul style="list-style-type: none"> Бэлчээрийн нөөцийн менежмент. <p>Төслийн 12 сарын дараа дор хаяж 600 малчны бүлэг газар ашиглалтын сайжруулсан арга зүйг ашиглаж, аймаг болгон ховор бэлчээрийн талбайг илүү оновчтой байдлаар ашиглана.</p>	<ul style="list-style-type: none"> 120 малчин өрхөд зориулан бэлчээр, усны менежментийг үзүүлсэн 2 төсөл хэрэгжүүлж, 22,000 мал, 140,000 га газар хамарсан [бэлчээрийн үйл ажиллагааны үр өгөөжөөс хүртэх хүмүүсийн 20 хувь]
<ul style="list-style-type: none"> Усны нөөцийн менежмент. <p>Төслийн 12 сарын дараа дор хаяж 400 малчны бүлэг усны ашиглалт, худгийн засвар үйлчилгээний төлөвлөгөөтэй болж, 200 гаруй усны суваг, худгийг малчдаас тодорхой хэмжээний санхүүжилтээр сэргээн засварлана.</p>	<ul style="list-style-type: none"> [усны менежментын үйл ажиллагааны үр өгөөжөөс хүртэх хүмүүсийн 30 хувь]
<ul style="list-style-type: none"> Хувийн хэвшлийн хөгжил. <p>Төслийн 12 сарын дараа дор хаяж төсөлд оролцогч 500 хоршоо, бизнесийн байгууллагууд зах зээлийн хүчин зүйд илүү уян хатан байж, ажлын бүтээмж нь дээшилж ашиг нэмэгдэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> 101 удаагийн бизнес сургалтад 1586 зээлдэгч хамрагдсан 34 удаагийн бизнес зөвлөмж өгсөн 5 компанид өөрчлөлт гаргах зөвлөмж өгсөн Сонгогдсон орон нутгийн 24 малчны бүлэг, хоршоонд арилжааны банкнаас зээл авахад нь 51.4 сая төгрөгийн бэлэн мөнгөний баталгааг банкинд гаргасан [тодорхойлсон хоршоодын 32 хувь]

2003 оны гэрээ, Мерси Кобын тайлан.

/Тайлангийн огноо: 2005 оны 10 дугаар сарын 21/

Үйл ажиллагааны зорилт нь хөдөөгийн агро бизнесийг хөгжүүлэх, хөгжлийг сайжруулах, зах зээлийн зарчмуудыг сурталчлах, тогтвортой эдийн засгийн хөгжлийг дэмжихэд оршино.

Монгол Улсын Засгийн газар хэлэлцээрийн дагуу борлуулалтын орлогыг ашиглан эдгээр зорилтуудыг дараахь төслийг дэмжсэнээр хэрэгжүүлнэ:

Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр нь малчдын амьжиргааны төрлийг нэмэгдүүлэхийн тулд малчдад малын тэжээлийн үр олгох, техник туслалцаа үзүүлэх, бага оврын сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ. Ингэснээр мал аж ахуй, газар тариалантай холбоотой бизнесийг дэмжихэд хувь нэмэр оруулах юм.

Хотын бизнес хөгжлийн төсөл нь Монголын хамгийн том хот, хурдан хөгжиж буй хот орчмын оршин суугчдын бизнесийн чадварыг тогтвортой нэмэгдүүлэхэд оршино.

Борлуулалтын орлогын ашиглалт

Төсөл	Борлуулалтын орлогын дүн /ам.долл/	Биелэлтийн хувь
Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр	2,075,297	73
Хотын бизнес хөгжлийн төсөл	691,766	24.5
Борлуулалтын зардал	<u>70,437</u>	<u>2.5</u>
Нийт	2,837,500	100

Гэрээний хэрэгжилтийн явцыг хэмжих шалгуурыг Мерси Кобын үр дүнгийн тайлантай харьцуулсан байдал

2003 оны гэрээний үйл ажиллагаа	Үр өгөөжийг хүртэх ёстой хүмүүсийн тоо	Мерси Кобын тайланд үр дүнг тэмдэглэсэн байдал
Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр		<i>Нийт болон жижиг төслүүдийн зарлагыг бичээгүй</i>
Сургалт, зөвлөгөө	50,000	<ul style="list-style-type: none">177 сургалтад 3,087 малчид хамрагдсан74 сургалтад 1,212 байгууллагууд бизнес сургалтад хамрагдсан85 орон нутгийн оролцогчид Улаанбаатар хотод зөвлөхийн сургалтад уригдсан.169 малын эмч Улаанбаатар хотод болсон сургалтад хамрагдсан. 105 оролцогчид 5 аймагт болсон сургалтад оролцсон. Оролцогчдод нийт 170.0 сая төгрөгийн үнэтэй эмийг тусламжаар өгсөн. <i>Нийт үр өгөөжийг хүртэгсэд 4,658 буюу тодорхойлсон түвшний 9 хувь</i>

Хөдөөгийн бизнес мэдээлэл	70,000	Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөр нь 4 газар сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдлын сурталчилгааны ажил явуулсан.
ХАА-н сэдэвт радио нэвтрүүлэг	350,000	Үнэлгээ хийхэд төлөвлөж байсан хүмүүсийн 75 хувьд хүрч чадсан гэж харуулсан. Ойролцоогоор 187,500 хүн – <i>тодорхойлсон үр өгөөж хүртээгсдийн 53 хувь</i>
<i>Гэрээнд тодорхойлогдоогүй ажил хийгдсэн</i>	Малын чанарыг сайжруулах технологийг малчдад үргэлжлүүлэн өгсөн	
Хотын бизнес хөгжил төсөл– хэрэгжүүлэгч CHF байгууллага	<i>Нийт болон жижиг төслүүдийн зарлагыг бичээгүй</i>	
Сургалтад оролцсон үйлчлүүлэгч	2,500	105 үйлчлүүлэгч бизнес төлөвлөлтийн сургалтад оролцсон– <i>үр өгөөжийг хүртээгсэд тодорхойлсон түвшний 4 хувь</i>
Зөвлөмж авч буй үйлчлүүлэгчдийн тоо	700	164 бизнес байгууллагад техник туслалцаа үзүүлсэн, тодорхойлсон түвшний 23 хувь
Одоогийн жижиг бизнес өргөжсөн эсвэл сайжирсан	500	Мэдээлэл тэмдэглэгдээгүй
Шинэ бизнес бий болсон	50	Мэдээлэл тэмдэглэгдээгүй
Шинээр бизнес эрхэлсэн байгууллагуудад олгосон зээлийн тоо	250	Нийт 753.2 сая төгрөгийн 248 зээлийг арилжааны банкаар дамжуулан олгосон. Үүнд: Хөдөөгийн агро бизнесийг дэмжих хөтөлбөрөөр зээлийн 69 хувийг мөнгөн барьцаа байдлаар банкинд гаргасан
Ажлын орон тоо бий болгож зохих ажилд оруулсан	2000	Мэдээлэл тэмдэглэгдээгүй
Бүх үйл ажиллагаа 12-18 сарын хугацаанд болно		Мэдээлэл тэмдэглэгдээгүй